



UIN.MN  
СУДАЛГААНЫ САН

# ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИУД ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ

- СУДАЛГААНЫ ТАЙЛАН -

Улаанбаатар хот. 2014 он

**Судалгааны багийн ахлагч:**

Ж.Бямбадорж

Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга

**Судалгааны багийн гишүүд:**

Г.Агар-Эрдэнэ

Хүний эрхийн Үндэсний Комисс

Ч.Алтангэрэл

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр

Ч.Ариунаа

Хүний эрхийн Үндэсний Комисс

Б.Болорсайхан

Хүний эрхийн Үндэсний Комисс

Э.Мөнхзул

Хүний эрхийн Үндэсний Комисс

Т.Саруул

Хууль зүйн үндэсний хүрээлэн

Э.Туул

Хүний эрхийн Үндэсний Комисс

Х.Цэцгээ

Хүний эрхийн Үндэсний Комисс

Д.Үүрцайх

Хууль зүйн үндэсний хүрээлэн

2014 он

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## Агуулга

Удиртгал 3

### **НЭГ. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН ..... 6**

- 1.1. Олон улсын түвшний бодлого тодорхойлох баримт бичгүүд ба Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр ..... 6
- 1.2. Дээд боловсрол дахь хүний эрхийн боловсролын стратегийг Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрт онцолсон нь ..... 11
- 1.3. Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын төлөв байдал ..... 17

### **ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДАД “ХҮНИЙ ЭРХ” ХИЧЭЭЛИЙГ ЗААЖ БУЙ НЬ..... 26**

- 2.1. Хууль зүйн их, дээд сургуулиудын “Хүний эрх” хичээл ..... 26
- 2.1.1. Их засаг олон улсын их сургуулийн Хууль зүйн сургууль..... 28
- 2.1.2. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль..... 29
- 2.1.3. Монголын Үндэсний Их Сургуулийн Хууль зүйн удирдлагын сургууль ..... 30
- 2.1.4. Орхон их сургуулийн Хууль зүйн сургууль ..... 31
- 2.1.5. Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургууль..... 32
- 2.1.6. Түшээ дээд сургууль ..... 33
- 2.1.7. Улаанбаатар их сургууль ..... 35
- 2.1.8. Үндэсний тагнуулын академи ..... 36
- 2.1.9. Хууль сахиулахын их сургууль ..... 37
- 2.1.10. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Билэг дээд сургууль ..... 40
- 2.1.11. Шихихутуг хууль зүйн дээд сургууль..... 41
- 2.2. Сэдвийн дүгнэлт..... 42
- Хавсралт №1** ..... 46
- Хавсралт №2 ..... 47

### **ГУРАВ. ЗАРИМ ГАДААДЫН ИХ СУРГУУЛИЙН ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТ ..... 51**

- 3.1. Англи саксоны эрх зүйн тогтолцооны улсууд: АНУ ба Австралийн жишээнд ..... 52
- 3.2. Эх газрын эрх зүйн тогтолцооны онцлог: ХБНГУ-ын жишээнд..... 55
- 3.3. Хөгжингүй улсуудын онцлог: Азийн зарим улсуудын жишээнд ..... 58
- 3.4. Сэдвийн дүгнэлт ..... 61

### **ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ ..... 64**

## Удиртгал

Олон улсын хамтын нийгэмлэгээс хүний эрхийг хангаж, хамгаалахад боловсрол чухал үүрэгтэйг хүлээн зөвшөөрч, “Хүний эрхийн боловсролын НҮБ-ын 10 жил” (1995-2004), “Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр” (2004), “Хүний эрхийн боловсрол, сургалтын тухай тунхаглал” (2011) зэрэг бодлогын баримт бичгүүдийг батлан хэрэгжүүлж байна. Эдгээр бодлогын хүрээнд Хүний эрхийн Үндэсний Комисс нь хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих үйл ажиллагаа явуулж, эрх зүйн боловсрол олгож буй хууль зүйн их, дээд сургуулиудад зориулан хүний эрхийн хичээлийн загвар хөтөлбөр боловсруулж, зарим сургуулиудад туршиж байсан билээ. Комисс 2012-2014 онд хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөөндөө “Бүх нийтэд хүний эрхийн боловсрол олгох үндэсний тогтолцоог бэхжүүлэх”, “Албан боловсролын тогтолцоогоор олгож буй хүний эрхийн боловсролын чанар, үр нөлөөг дээшлүүлэх” зорилго, зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна.

Энэхүү зорилтыг хангахын тулд албан боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсрол олгож буй үйл ажиллагаанд үнэлгээ, мониторинг хийх, энэ талаар холбогдох талуудын байр суурь, ололт амжилт, хамтын ажиллагааг тодорхойлох, нэгтгэн дүгнэх, цаашид сайжруулах талаар нэгдмэл ойлголтод хүрэх шаардлагатай байна. Иймд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн “Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх” төслийн хүрээнд эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт “Хүний эрх” хичээл тусгагдсан эсэх, уг хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээг харьцуулан судлах ажлыг Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гүйцэтгэв.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1-т “хүний эрхийн асуудлаар судалгаа явуулж, шаардлагатай мэдээллээр хангах”, 13.2.5-д “Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих” гэснийг тус тус үндэслэн энэхүү судалгааны ажлыг гүйцэтгэсэн болно.

### Судалгааны зорилго, зорилтууд

Эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгож буй байдал, сургалтын хөтөлбөр дэх “Хүний эрх”, түүнтэй холбоотой хичээл, сургалт, тэдгээрийн агуулга, арга зүй, хүний эрхийн сэдвийн хүрээнд хичээлийн болон хичээлээс гадуур зохион байгуулагдаж буй боловсролын хөтөлбөртэй танилцаж, улмаар дээд боловсролын түвшинд хүний эрхийн боловсролыг дэмжих талаар арга зүйн санал, зөвлөмж боловсруулах зорилго тавьж ажиллахдаа дараах зорилтыг дэвшүүлсэн болно:

1. Хүний эрхийн боловсролын талаарх НҮБ-ын бодлого, Монгол Улсын төрийн бодлого, эрх зүйн орчин зэрэгт баримт бичгийн шинжилгээ хийх;
2. Эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөр дэх “Хүний эрх”, түүнтэй холбоо бүхий хичээлүүдийн агуулгатай танилцах;

3. Бусад улсын хуулийн их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсролыг хэрхэн түгээж буй туршлага, арга зүйг судлах;

4. Судалгааны үр дүнд үндэслэн хүний эрхийн боловсролыг дэмжих чиглэлээр цаашид авч хэрэгжүүлбэл зохих үйл ажиллагаа, арга хэмжээний тухай санал, зөвлөмж гаргах.

### **Судалгааны арга зүй:**

Судалгааг суурин дүн шинжилгээний аргачлалаар хийсэн ба уг судалгаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг, эрх зүйн боловсрол олгож буй 11 их дээд сургуулиудаас холбогдох мэдээллийг гаргуулан авч ажилласан ба бичиг баримтын дүн шинжилгээ хийх, мэдээлэл цуглуулах, харьцуулалт, дүгнэлт хийх арга зүйг ашиглалаа.

Ялангуяа, “Хүний эрх” хичээлийг заах хөтөлбөр, арга зүй, сургалтын үнэлгээ, кредит цаг, хамрах хүрээ, эрх зүйч мэргэжлийн сургалтын хөтөлбөр дэх “Хүний эрх”, түүнтэй ижил төсөөтэй хичээлүүдийн хөтөлбөр, тухайн хичээлийг сонгон судалсан оюутны тоон мэдээлэл зэрэгт голлон анхаарлаа.



**Товчилсон үгсийн жагсаалт:**

БСХМТ - Боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө  
БШУЯ – Боловсрол, шинжлэх ухааны яам  
ИУТЭОУП – Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт  
МУБИС – Монгол Улсын Боловсролын их сургууль  
МУИС – Монгол Улсын Их Сургууль  
МҮИС – Монголын Үндэсний Их Сургууль  
НҮБ – Нэгдсэн үндэстний байгууллага  
ОУХБ – Олон Улсын Хөдөлмөрийн байгууллага  
ӨАХСХЭФ - Өмнөд Азийн Хуулийн Сургуулиудын Хүний Эрхийн Форум  
ТББ – Төрийн бус байгууллага  
ТЕГ – Тагнуулын ерөнхий газар  
ХЗЯ – Хууль зүйн яам  
ХЭБДХ – Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр  
ХЭДКГ - Хүний эрхийн Дээд Комиссарын газар  
ХЭҮБ – Хүний эрхийн үндэсний байгууллага  
ХЭҮК – Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс  
ХЭХҮХ – Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр  
ЭЗНСЭОУП – Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт  
ЭНХ – Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг  
ЮНЕСКО – НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага

# НЭГ. ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН БОДЛОГО, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

## 1.1. Олон улсын түвшний бодлого тодорхойлох баримт бичгүүд ба Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр

Олон улсын хамтын нийгэмлэгээс хүний эрхийг хэрэгжүүлэхэд хүний эрхийн боловсролын хувь нэмэр чухал болохыг сануулсаар байна. Хүний эрхийн боловсрол нь олон нийт, нийгэм бүрт хүний эрхийг бодитой эдлүүлэх нийтлэг үүрэг хариуцлагыг бий болгоход чиглэдэг. Тийм ч учраас энэ нь хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд үр дүнгээ өгдөг, тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмждэг, ардчилсан тогтолцоонд шийдвэр гаргах үйл явцыг сайжруулах үндсэн механизм болдог.

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, сахин хамгаалах мэдлэг, чадвар, хандлага болон зан үйлийг төлөвшүүлэх насан туршийн үйл явц юм. Энэ нь НҮБ-ын дэлхийг хамарсан санаачилга болох Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр (ХЭБДХ)-ийн чиглэл болдог ба 2005 оноос хойш тус хөтөлбөрийн дагуу бүх салбарт хүний эрхийн боловсролыг тусгах бодит арга хэмжээ авахыг уриалсан билээ. ХЭБДХ-ийн эхний үе<sup>1</sup> (2005-2009) нь сургуулийн тогтолцоонд түлхүү анхаарсан бол Хөтөлбөрийн 2 дахь үе<sup>2</sup> нь өмнөх таван жилийн ололт дээрээ тулгуурлан (2010-2014) ирээдүйн иргэд, удирдагчдыг сургах, тухайлбал, дээд боловсролын байгууллагууд болон хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг хүлээсэн төрийн албан хаагчид, хууль сахиулагчид, цэргийн албан хаагчдад чиглэсэн байна. 2 дахь үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөг НҮБ-ын Хүний эрхийн Зөвлөл 2010 оны 9 дүгээр сард батлах үед НҮБ-ын гишүүн улсууд дээрх салбарт хүний эрхийн боловсролын бодлого боловсруулж, практик дээр хяналт тавьж ажиллахаар тохиролцсон болно. Энэхүү төлөвлөгөө нь Засгийн газрууд болон бусад байгууллагуудад бодлого, төлөвлөлт хийх үйл явц, төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлэх асуудлаарх практик удирдамж юм.

Ийнхүү НҮБ-ын Хүний эрхийн Дээд Комиссарын газар (ХЭДКГ) нь ЮНЕСКО, НҮБ-ын бусад төрөлжсөн байгууллагууд, олон улсын, бүсийн байгууллагуудтай хамтарч гишүүн улсууд болон бусад байгууллагуудын хүний эрхийн боловсролын хэрэгжилтэд туслалцаа үзүүлж, зохицуулалт хийхээр уялдаа холбоотой ажиллаж байна.

Хүний эрхийн боловсролын талаар олон улсын гэрээ, конвенц болон баримт бичигт цөөнгүй тусгасан байдаг. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал<sup>3</sup>-ын 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход

<sup>1</sup> <http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N05/253/74/PDF/N0525374.pdf?OpenElement>

<sup>2</sup> <http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/G10/151/48/PDF/G1015148.pdf?OpenElement>

<sup>3</sup> [http://www.ohchr.org/EN/UDHR/Documents/UDHR\\_Translations/khk.pdf](http://www.ohchr.org/EN/UDHR/Documents/UDHR_Translations/khk.pdf)



чиглэх ёстой. Боловсрол нь аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах, мөн түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагаас энх тайвныг сахиулах талаар явуулж буй үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх ёстой.” гэж заасан ба Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт<sup>4</sup>-ын 13 дугаар зүйл, Арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай конвенц<sup>5</sup>-ийн 7 дугаар зүйл, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц<sup>6</sup>-ийн 10 дугаар зүйл, Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг устгах тухай конвенц<sup>7</sup>-ийн 10 дугаар зүйл, Хүүхдийн эрхийн тухай конвенц<sup>8</sup>-ийн 10 дугаар зүйл, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц<sup>9</sup>-ийн 4, 8 дугаар зүйл, Венийн Тунхаглал ба үйл ажиллагааны хөтөлбөр<sup>10</sup>-ийн 1 дүгээр хэсгийн 33-34 дүгээр бүлэг, 2 дугаар хэсгийн 78-82 дугаар бүлэг зэрэгт тусгалаа олжээ. Түүнчлэн бусад олон улсын баримт бичгүүд цөөнгүй бий<sup>11</sup>.

Дээрх олон улсын гэрээ, конвенцуудын хүрээнд хүний эрхийн боловсролыг “хүний эрхийн түгээмэл соёлыг бий болгоход чиглэсэн аливаа суралцах хүчин чармайлт, мэдээлэл, боловсрол болон сургалт” гэж мөн тодорхойлж болно. Эдгээр нь дараах цогц үйл явцыг хамарч байна:

- а) хүний үндсэн эрх, эрх чөлөөг хүндэтгэх явдлыг бэхжүүлэх;
- б) хүний зан чанар болон хүний нэр төрийг төгс хөгжүүлэх;
- в) бүх үндэстэн, уугуул иргэд болон цөөнхийн хоорондын ойлголцол, хүлээн зөвшөөрөх буюу хүлцэх байдал, жендэрийн тэгш байдлыг хөхиүлэн дэмжих;
- г) хуулийг дээдэлсэн, чөлөөт, ардчилсан нийгэмд хүн бүр үр дүнтэй оролцох явдлыг хангах;
- д) энх тайвныг тогтоох;
- е) хүн төвтэй тогтвортой хөгжил ба нийгмийн шударга ёсыг хөхиүлэн дэмжих зэрэг болно.

Эндээс үзвэл хүний эрхийн боловсрол нь дараах зүйлсийг агуулж байна:

- а) Мэдлэг, чадвар – хүний эрх ба түүнийг хамгаалах тогтолцооны талаар суралцах, өдөр тутмын амьдралд практик хэлбэрээр ашиглах чадварыг эзэмших;

<sup>4</sup> <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CESCR.aspx>

<sup>5</sup> <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CERD.aspx>

<sup>6</sup> <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CAT.aspx>

<sup>7</sup> <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CEDAW.aspx>

<sup>8</sup> <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/CRC.aspx>

<sup>9</sup> <http://www.ohchr.org/EN/HRBodies/CRPD/Pages/ConventionRightsPersonsWithDisabilities.aspx>

<sup>10</sup> <http://www.ohchr.org/en/professionalinterest/pages/vienna.aspx>

<sup>11</sup> Declaration and Programme of Action of the World Conference against Racism, Racial Discrimination, Xenophobia and Related Intolerance, 2001 /Dec. paras.95-97, Programme of Action, paras. 129-139/, Outcome Document of the Durban Review Conference, 2009 /paras. 22;107/, 2005 World Summit Outcome /para.131/



б) Үнэ цэнэ, хандлага болон зан үйл. Үнэ цэнийг бий болгох, хүний эрхийг сахин хамгаалах хандлага, зан үйлийг бэхжүүлэх;

в) Үйл ажиллагаа буюу арга хэмжээ – хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих арга хэмжээ авах зэрэг болно.

Тэгвэл одоо хэрэгжиж буй НҮБ-ын ХЭБДХ нь дараах зорилтыг тавьжээ.

а) Хүний эрхийн соёлыг хөхиүлэн дэмжих;

б) Олон улсын гэрээ конвенцид тулгуурлаж хүний эрхийн боловсролын талаарх үндсэн зарчмууд болон арга зүйн нийтлэг ойлголтыг хөхиүлэн дэмжих;

в) Үндэсний, бүсийн, олон улсын түвшинд хүний эрхийн боловсролд голлон анхаарах явдлыг хангах;

г) Холбогдох бүх талуудын авах арга хэмжээний нийтлэг хамтын баримт бичгийг гаргах;

д) Бүх түвшинд түншлэл, хамтын ажиллагааг сайжруулах;

е) Одоогийн хүний эрхийн боловсролын хөтөлбөрт судалгаа хийх, үнэлгээ өгөх болон дэмжих, сайн туршлагыг онцлон тэмдэглэх, хөтөлбөрийг үргэлжлүүлэх, эсхүл өргөжүүлэх сэдлийг бий болгох ба хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах зэрэг болно.

Улмаар ХЭБДХ-т хүний эрхийн боловсролын үйл ажиллагааны зарчмыг ийнхүү тодорхойлжээ:

а) Иргэний, улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрх болон хөгжих эрх зэрэг хүний эрхийн харилцан хамааралтай, салшгүй, хуваагдашгүй, түгээмэл зарчмыг хөхиүлэн дэмжих;

б) Ялгаатай байдлыг хүндэтгэх хандлагыг дэмжих, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төр болон бусад үзэл санаа, үндэстний, цөөнхийн аль эсхүл нийгмийн гарал, биеийн эсхүл оюуны санааны байдал, бэлгийн баримжаа болон бусад асуудлаар нь ялгаварлах явдлыг эсэргүүцэх;

в) Цаг үеийн болон тулгамдаж буй хүний эрхийн асуудал (ядуурал, зөрчил тэмцэл, ялгаварлан гадуурхалт гэх мэт)-уудад дүн шинжилгээ хийхийг уриалах, түүнчлэн хүний эрхийн стандартад нийцүүлж улс төр, нийгэм, эдийн засаг, технологи болон экологийн салбарын хурдацтай өөрчлөгдөж буй хөгжилд дүн шинжилгээ хийх явдлыг хөхиүлэн дэмжих;

г) Олон нийт болон хувь хүмүүс хүний эрхийн хэрэгцээгээ тодорхойлж, түүнийгээ үр дүнтэй шаардах явдлыг бэхжүүлэх;

д) Хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хангах үүрэг хүлээгчид, ялангуяа төрийн албан хаагчдад энэхүү үүргээ биелүүлэх чадавхийг олгох;

е) Хүний эрхийн зарчмыг соёлын ялгаатай түвшинг харгалзан бий болгох, улс бүрийн түүх, нийгмийн хөгжлийг анхаарч үзэх;

ё) Хүний эрхийг хамгаалах орон нутгийн, бүсийн, олон улсын хүний эрхийн гэрээ, конвенц болон хүний эрхийн механизмыг ашиглах мэдлэг чадварыг сайжруулах;

ж) Хүний эрхийг хөгжүүлэхэд шаардагдах оролцооны арга зүйг сургалтад ашиглах;

з) Оролцоог дэмжиж, хүний эрхийг хангаж, хүний зан чанарыг бүрэн дүүрэн хөгжүүлэх явдлыг уриалсан, сэтгэл хөдлөл болон дарамтаас ангид заах арга болон сурах орчныг сайжруулах;

к) Суралцагчидтай абстракт хэм хэмжээнээс авахуулаад өдөр тутмын амьдрал, нийгэм, эдийн засаг, соёлын болон улс төрийн бодит нөхцөл байдалтай холбох замаар тэдэнтэй хүний эрхийн талаар харилцан ярилцаж ойлгуулах.

ХЭБДХ-ийн 2 дахь үе (2010-2014)-д дээд шатны боловсрол дахь хүний эрхийн боловсрол болон төрийн албан хаагчид, хууль сахиулах байгууллагын ажилтнууд болон цэргийн албаны үйл ажиллагааны төлөвлөгөө багтсан болохыг өмнө дурдсан. Хүний эрхийн Зөвлөлийн 12/4 тоот тушаалын дагуу ХЭБДХ-ийн 2 дахь үе нь “дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол болон бүх шатны багш, сурган хүмүүжүүлэгч, төрийн албан хаагчид, хууль сахиулагчид болон цэргийн албан хаагчдад зориулсан хүний эрхийн сургалтын хөтөлбөр” дээр голлон анхаарах ба “Гишүүн улсууд бага болон дунд сургуулийн тогтолцоонд хүний эрхийн боловсролын хэрэгжилтийг үргэлжлүүлэх ёстой.” байна.

Дээд боловсролын хувьд энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөө нь хүний эрх болон боловсролын тухай гэрээ конвенц, баримт бичгүүд, тухайлбал, Хүний эрхийн Түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай конвенц болон Хүүхдийн эрхийн хорооноос гаргасан холбогдох гарын авлага (ялангуяа боловсролд чиглэсэн 2001 оны Ерөнхий зөвлөмж №1), Эдийн засаг, нийгмийн соёлын эрхийн тухай олон улсын пакт болон Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн Хорооны холбогдох удирдамж (Сурч боловсрох эрхийн тухай 1999 оны Ерөнхий зөвлөмж №13), Венийн Тунхаглал, түүний үйл ажиллагааны хөтөлбөр, ЮНЕСКО-гийн Хүний эрх, үндсэн эрх чөлөөний асуудлаарх олон улсын ойлголт, хамтын ажиллагаа, энх тайван болон боловсролын тухай зөвлөмж<sup>12</sup>, ЮНЕСКО-гийн Энх тайван, хүний эрх ба ардчиллын төлөөх боловсролын Тунхаглал болон үйл ажиллагааны нэгдсэн баримт бичиг<sup>13</sup>, ЮНЕСКО-гийн Боловсрол дахь ялгаварлан гадуурхалтын эсрэг конвенц<sup>14</sup>,

<sup>12</sup> [http://www.unesco.org/education/nfsunesco/pdf/Peace\\_e.pdf](http://www.unesco.org/education/nfsunesco/pdf/Peace_e.pdf)

<sup>13</sup> [http://www.unesco.org/education/nfsunesco/pdf/REV\\_74\\_E.PDF](http://www.unesco.org/education/nfsunesco/pdf/REV_74_E.PDF)

<sup>14</sup> [http://portal.unesco.org/en/ev.php-URL\\_ID=12949&URL\\_DO=DO\\_TOPIC&URL\\_SECTION=201.html](http://portal.unesco.org/en/ev.php-URL_ID=12949&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html)

ЮНЕСКО-гийн Дээд боловсрол дахь сургалт, чанарыг хүлээн зөвшөөрсөн асуудлаарх болон холбогдох бүс нутгийн конвенцуудын талаарх зөвлөмж<sup>15</sup>, ЮНЕСКО-гийн Дээд боловсрол заах албан хаагчдын статустай холбоотой зөвлөмж<sup>16</sup>, ЮНЕСКО-гийн 21 дүгээр зууны дээд боловсролын асуудлаарх дэлхийн Тунхаглал, Алсын хараа ба үйл ажиллагаа<sup>17</sup>, 2009, 2012 оны ЮНЕСКО-гийн Дээд боловсролын дэлхийн бага хурал “Дээд боловсролын шинэ динамик болон нийгмийн өөрчлөлт, хөгжлийн төлөөх судалгаа”<sup>18</sup> сэдэвт бага хурлын эцсийн баримт бичиг зэрэгтэй харилцан уялдаатай байна.

Түүнчлэн бүх нийтийн боловсролын үйл ажиллагааны Дакарын баримт бичиг<sup>19</sup> -ийг энд дурдаж болно. Дакарын баримт бичиг нь боловсролын агуулгын чанарын үндсийг тодорхойлсон ба энэ нь ардчилсан иргэн болон эв нэгдлийг (нийтлэг эрх ашгийг) хөхиүлэн дэмжих хандлагын төлөөх чадварыг бий болгоход чиглэдэг.

Ийнхүү НҮБ-аас хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн олон улсын хэм хэмжээ, тунхаглал, үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг батлан гаргасныг товчхон авч үзэхэд ийм байна.

---

<sup>15</sup> [http://www.unesco.org/education/studyingabroad/tools/recommendation\\_cover.shtml](http://www.unesco.org/education/studyingabroad/tools/recommendation_cover.shtml)

<sup>16</sup> [http://portal.unesco.org/en/ev.php-URL\\_ID=13144&URL\\_DO=DO\\_TOPIC&URL\\_SECTION=201.html](http://portal.unesco.org/en/ev.php-URL_ID=13144&URL_DO=DO_TOPIC&URL_SECTION=201.html)

<sup>17</sup> [http://www.unesco.org/education/educprog/wche/declaration\\_eng.htm](http://www.unesco.org/education/educprog/wche/declaration_eng.htm)


<sup>18</sup> [http://www.unesco.org/fileadmin/MULTIMEDIA/HQ/ED/ED/pdf/WCHE\\_2009/FINAL%20COMMUNIQUE%20WCHE%202009.pdf](http://www.unesco.org/fileadmin/MULTIMEDIA/HQ/ED/ED/pdf/WCHE_2009/FINAL%20COMMUNIQUE%20WCHE%202009.pdf)

<sup>19</sup> <http://www.unesco.org/education/wef/en-conf/dakframeng.shtml>


## 1.2. Дээд боловсрол дахь хүний эрхийн боловсролын стратегийг Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрт онцолсон нь

Судалгааны энэхүү хэсэгт дээд боловсрол дахь хүний эрхийн боловсролын стратегийг хэрхэн тодорхойлох, хэрэгжүүлэх талаар НҮБ-ын ХЭБДХ-ийн 2 дахь үед хэрхэн тусгасныг авч үзье.

ХЭБДХ-ийн 2 дахь үед тодорхойлсноор дээд боловсрол дахь хүний эрхийн боловсрол нь дараах асуудлыг багтаасан үйл явц юм:



Дээд боловсролын тогтолцоонд энэхүү хандлагыг үр нөлөөтэйгээр бий болгохын тулд дараах таван хэсэгт зайлшгүй үйл ажиллагаа явуулах хэрэгтэйг ХЭБДХ онцолжээ.



Эдгээрийг тус бүрт нь авч үзье.

### 1. Бодлогын хэрэгжилтийг хангах арга хэмжээ

Хүний эрхийн боловсролын бодлого боловсруулах, батлах болон хэрэгжүүлэх, мөн хүний эрхийг боловсролын бодлогод тусгах үйл явц нь

институтын хараат бус байдал болон академик эрх чөлөөг хангасан байх ёстой ба тухайн улсын боловсролын тогтолцоонд тохирсон эрх, үүрэг, хариуцлагатай байх нь чухал болохыг авч үзжээ. Бодлогыг оролцоонд тулгуурлаж боловсруулах ба багшлах боловсон хүчний холбоо болон холбогдох талуудыг оролцуулахыг зөвлөсөн байна.

ХЭБДХ-т зааснаар дээд боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролын бодлогыг тодорхойлоход дараах онцлог асуудлыг тусгах ёстой. Үүнд:

а) Дээд боловсрол, ялангуяа хүний эрхийн боловсролд хүний эрхийг тусгах үүднээс бодлого, хууль тогтоомжийг боловсронгуй болгох. Ингэхдээ бүх хууль тогтоомж хүний эрхийн боловсролын зарчимтай нийцэж байгаа эсэхэд хяналт үнэлгээ хийх; бодлого, зохицуулалтыг боловсруулахдаа хүний эрхийн зарчимд нийцүүлж хүний эрхийн боловсролд хийсэн судалгаанд үндэслэх; хүний эрхийн зарчмыг хүндэтгэдэг багшлах боловсон хүчнийг дэмжих бодлого, практик бий болгох; дээд боловсрол нь хүн бүрт хүртээмжтэй байх, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг эмзэг бүлгийн хүмүүст ч хүртээмжтэй байх явдлыг хангах болон аливаа ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого боловсруулж хэрэгжүүлэх; холбогдох мэргэшлийн гэрчилгээ, эсхүл тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий төрийн байгууллагад хүний эрхийн сургалтыг шалгуур үзүүлэлт болгон хэрэглэх зэрэг юм.

б) Харилцан уялдаа, хамтын хүчин чармайлтыг бодлогод тусгах. Тухайлбал, хүний эрхийн боловсролыг дээд боловсролын үндэсний төлөвлөгөөнд оруулах; Бүх нийтэд зориулсан боловсролын үндэсний төлөвлөгөө, Тогтвортой хөгжлийн төлөөх боловсролын /2005-2014/ 12 жилийн үндэсний төлөвлөгөө болон оролцоонд тулгуурласан боловсролын бодлогод тусгах; мөн ядуурлыг бууруулах үндэсний стратеги болон бусад хөгжлийн баримт бичгүүдэд тусгах.

в) Багшлах боловсон хүчинд зориулж хүний эрхийн сургалтын нэгдсэн бодлогыг батлахдаа дараах асуудлыг тусгах. Үүнд, сургагч багш нарын сургалт, багшлах боловсон хүчний дадлагын болон мэргэжлийн сургалт явуулах; багшлах боловсон хүчнийг тэдний эрх, үүрэг хариуцлага болон оролцооны талаарх мэдээллээр хангах; хүний эрхийн боловсролын салбарт сургалт явуулж буй ТББ-ууд болон иргэний нийгмийн бусад салбарынхныг магадлан итгэмжлэх, дэмжих; хүний эрхийн боловсролыг боловсролын ажилтнуудын мэргэшлийн чадвар, магадлан итгэмжлэл болон хувь хүний мэргэжлээрээ өсөн дэвжих шалгуур үзүүлэлт болгох; хүний эрхийн сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт болон стандартыг боловсруулах.

г) Хүний эрхийн боловсролын асуудлаар олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэх. Үүнд сурч боловсрох эрх болон хүний эрхийн сургалтын асуудлаарх олон улсын гэрээ конвенцийг соёрхон батлах явдлыг хөхиүлэн дэмжих; НҮБ-ын гэрээний байгууллагууд болон ЭНХ зэрэг холбогдох олон улсын механизмд хүргүүлэх үндэсний илтгэлдээ хүний эрхийн боловсролын тухай мэдээлэл оруулж, илтгэлийг боловсруулахад хүний эрхийн боловсролоор мэргэшсэн ТББ-ууд болон иргэний нийгмийн бусад

салбартай хамтрах; НҮБ болон бусад олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийг олон нийтэд хүргэх, хэрэгжүүлэх;

Боловсролын үр дүнтэй бодлого боловсруулах, шинэчлэл хийхэд гагцхүү цаасан дээрх бодлогын мэдэгдэл төдийгүй тодорхой арга хэмжээ, механизм, үүрэг хариуцлага, хөрөнгө гэх мэт хэрэгжилтийн стратеги шаардлагатай. Холбогдох бүх талуудыг оролцуулсан хэрэгжилтийн ийм стратеги нь бодлогын уялдаа холбоо, хяналт үнэлгээ болон хариуцлагыг хангаж чадна гэж ХЭБДХ үздэг.

## **2. Багшлах болон суралцах үйл явц, арга барил**

Дээд боловсролын тогтолцоонд хүний эрхийн боловсролыг нэвтрүүлэх, сайжруулахад хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, эх сурвалж, арга зүй, үнэлгээгээр дамжуулан суралцах болон багшлах цогц хандлагыг бий болгох хэрэгтэй. Эдгээр нь үндэсний түвшинд бодлого боловсруулагчид, дээд боловсролын институтууд, мөн зарим тохиолдолд багшлах боловсон хүчинд хандсан байдаг. Үүнд:

а) Багшлах болон суралцах хөтөлбөр, курсын хувьд дээд боловсролын бүх салбарт хүний эрхийг нийтлэг шинжээр нь тусгах стратеги боловсруулах. Өөрөөр хэлбэл зөвхөн хууль, нийгмийн ухаан гэлтгүй техникийн шинжлэх ухааны салбарт ч тусгах хэрэгтэй. (Жишээлбэл, архитектур, инженерийн салбар нь хөгжил бүтээн байгуулалт, байгаль орчин, барилгажилт, анагаах ухааны салбар нь хүүхдийн халамж, нийтийн эрүүл мэнд, эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрх, ХДХВ/ДОХ, хөгжлийн бэрхшээлийн асуудалтай холбоотой г.м); бүх салбарт суралцаж буй оюутнуудад хүний эрхийн удиртгал хичээл багшлахыг санал болгох; хүний эрхийн тухай ахисан түвшний курс санал болгох; хүний эрхийн магистр болон докторын хөтөлбөрүүдийг бий болгох; төрөл бүрийн хичээл, хичээл хоорондын хүний эрхийн академик хөтөлбөрүүдийг боловсруулах.

б) Сургалтын хэрэглэгдэхүүний хувьд суралцах бичиг, гарын авлагуудыг хүний эрхийн зарчимтай нийцүүлэх үүднээс дахин хянаж, засварлах; сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулахдаа соёл, түүх, нийгмийн хөгжлөөс улбаатай гарч ирсэн хүний эрхийн зарчимд нийцүүлэх; хүний эрхийн боловсролын хэрэглэгдэхүүнийг түүвэрлэх, орчуулахыг дэмжих; тухайн улс дахь НҮБ-ын байгууллагуудаас гаргасан хүний эрхийн боловсролын материалуудыг багшлах, суралцах болон судалгааны материал болгож ашиглах.

в) Багшлах болон суралцах туршлага, арга зүйн хувьд хүний эрхтэй уялдаа холбоотой багшлах хэв маяг/арга барилыг сонгох буюу хэрэглэх, тухайлбал, сурагч бүрийн хүний эрх, нэр төр болон өөрийгөө хүндлэх үзлийг нь хүндэтгэх, соёлын асуудлыг нь харгалзан үзэх; сурагчдыг харилцан идэвхтэй оролцоог дэмжих сурагч төвтэй арга барил, хандлагыг хэрэглэх; суралцагчдад хүний эрхийн үзэл баримтлалыг ойлгуулж, өөрсдийн өдөр тутмын амьдрал, туршлага, судалгаа, үйлчилгээнд хүний эрхийн үзэл баримтлалаа ашиглах боломжийг олгох туршлагаар олж тогтоосон суралцах арга барилыг хэрэглэх; хүний эрхийг багшлах үйл явцыг төлөвлөхдөө эзэмшвэл зохих хүний эрхийн мэдлэг, чадварыг тодорхойлж, танин мэдэхүйн



(мэдлэг, чадвар) болон нийгмийн/сэтгэл хөдлөлийн (үнэ цэнэ, хандлага, зан үйл) суралцах үр дүнд адил ач холбогдол өгөх; хүний эрхийн боловсролд чанарын баталгааны тусгай механизмыг байгуулах.

г) Багшлах, суралцах дэмжлэг туслалцаа болон эх сурвалжийн хүрээнд дээд боловсролын институтад хүний эрхийн тогтвортой хөтөлбөр бий болгох, хөгжүүлэхийг хөхиүлэн дэмжих үүрэг бүхий хүний эрхийн сургалт, мэдээлэл, эх сурвалжийн төвийг байгуулах, хөгжүүлэх; хүний эрхийн талаарх мэдээ, мэдээлэл харилцан солилцох, хэлэлцэх, сүлжээ үүсгэх; цахим сургалтын хөтөлбөр, цахим форум, вэб бага хурал болон холын зайны сургалтын хөтөлбөрийг боловсруулах.

### **3. Судалгаа**

Хүний эрхийн салбарт шинэ мэдлэгийг бий болгох, хөгжүүлэхэд дээд боловсрол чухал үүрэгтэй болохыг ХЭБДХ онцолсон билээ. Дээд боловсрол нь судалгаа хийх замаар хүний эрхийн боловсролын бодлого болон туршлага, практикийг дараах стратегиар дамжуулан мэдээлэх ёстой гэж ХЭБДХ-т заасан байна. Үүнд:

а) Одоо байгаа туршлага, практик, сургамж болон үнэлгээний ажилд хийсэн дүн шинжилгээ, үнэлгээнд үндэслэж хүний эрхийн боловсролын шинэлэг, үр дүнтэй арга барил, хэрэгслийг боловсруулахад хувь нэмэр оруулах судалгааг дэмжих; хүний эрхийн зарчим, хүний эрхийн тухайлсан гэрээ конвенцуудыг (засгийн газрын бодлого, хөтөлбөрүүд, бизнесийн туршлагууд, олон нийтийн санал санаачилга гэх мэт) орчуулах ажлыг дэмжих, санхүүжүүлэх; хүний эрхийн боловсролын сайн туршлагуудыг түүвэрлэх, түгээн дэлгэрүүлэх;

б) Дээд боловсролын байгууллагуудын судлаачид, ТББ-ууд, бусад иргэний нийгмийн байгууллагууд, ХЭҮБ-ууд болон олон улсын байгууллагуудын хооронд харилцан мэдээлэл солилцож, түншлэл бий болгох; хүний эрхийн мэдээллийн төв, номын сан байгуулж, дэмжих талаар ул суурьтай бодлого хэрэгжүүлэх; хүний эрхийн судалгаа, шинжилгээний ажилд зориулж техник хэрэгслээр хангах; хүний эрхийн судалгааг хөхиүлэн дэмжих үүднээс тэтгэлэгт хөтөлбөрүүдийг дэмжих, олон улсын судалгаа, санал асуулга болон харьцуулсан судалгаанд оролцох.

### **4. Суралцах орчин**

Дээд боловсролын зорилт, практик болон дээд боловсролын байгууллагуудын зохион байгуулалт нь хүний эрхийн зарчимтай дараах стратегид нийцэх ёстойг ХЭБДХ онцолжээ. Үүнд:

а) Оюутнууд болон багшлах боловсон хүчний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлсон дүрэм журам; хүчирхийлэл, бэлгийн дарамт, биеэр эдлүүлэх шийтгэлээс ангид байх тухай дээд боловсролын байгууллагуудын дүрэм журмыг батлан мөрдүүлэх; сургуулийн элсэлт, тэтгэлэг, хөгжлийн тусгай хөтөлбөрүүдэд ялгаварлахгүй байх бодлогыг тухайлан тусгах;



б) Багшлах боловсон хүчний хувьд, тэдний хүний эрхийн боловсролын асуудлаарх удирдлагын бүрэн эрхийг хангаад зогсохгүй тэдэнд хүний эрхийн боловсролын шинэ, сайн туршлагыг боловсруулах, хэрэгжүүлэх боломжийг олгох;

в) Дээд боловсролын байгууллагын багш нарын хүний эрхийг хамгаалж, хүндэтгэх ба дээрх байгууллагуудын ажилтнуудыг дэмжих бодлого батлах; оюутнууд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, шийдвэр гаргахад оролцох, өөрсдийн үйл ажиллагааг зохион байгуулах, хүсэл сонирхлоо илэрхийлэх, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг хангах, хүний эрхийн асуудлаар сургалтын төлөвлөгөөнөөс гадуур оюутнуудын хийж буй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

г) Хүний эрхийн талаарх олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, залуусын бүлэг, иргэний нийгэм болон орон нутгийн удирдлагуудтай хамтарч баяр ёслол, бага хурал, үзэсгэлэн гэх мэт тусгай арга хэмжээг зохион байгуулах;

## **5. Дээд боловсрол олгох боловсон хүчний боловсрол, мэргэжлийн хөгжил дэвшил**

Багшлах боловсон хүчин нь мэргэжлийн үүрэг хариуцлагаа хэрэгжүүлж байхдаа, мөн албан үүрэгтээ үлгэр дууриал болох үүднээс хүний эрхийн үнэ цэнэ, чадвар, хандлага, хөдөлгөх хүч, сэдэл болон туршлагыг түгээж байх үндсэн үүрэгтэй. Тиймээс тэдний мэргэжлийн статусыг хүлээн зөвшөөрч, хүндэтгэх мөн хүний эрхийн зохих сургалт явуулах нь чухал ач холбогдолтой.

Дээд боловсрол олгох боловсон хүчний боловсрол, мэргэжлийн хөгжил дэвшлийн хүрээнд тэдний хүний эрхийн боловсролын асуудлыг шийдвэрлэхэд дараах стратегийг оруулахыг зөвлөсөн. Үүнд:

а) Багшлахаас өмнөх болон зааж буй шатан дахь хүний эрхийн боловсролын сургалтад хүний эрх, хүний эрхийн түгээмэл, хуваагдашгүй, харилцан хамааралтай байдал болон хамгаалалтын механизмын талаарх мэдлэг, ойлголт; олон төрлийн хичээлийг хамарсан болон хичээл хоорондын хүний эрхийн өнцөг; хүний эрхийн боловсролыг үндэс суурь болгож буй боловсролын онолууд, тухайлан албан, албан бус боловсрол хоорондын холбоог оролцуулах; багшлах, суралцах арга зүй болон багшлах боловсон хүчний үүрэг роль; ардчилсан, хүний эрхийн зарчимтай уялдаатай багшлах боловсон хүчний нийгмийн чадвар болон манлайллын хэв маяг; багшлах боловсон хүчин болон оюутнуудын эрх ба үүрэг хариуцлага; болон хүний эрхийн боловсролын одоо байгаа материалуудын талаарх мэдээлэл, эдгээр материалыг хянаж үзэх, сонгох болон шинэ материал боловсруулах үүднээс дээд-боловсрол олгох боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх талаар тус тус оруулж боловсруулах.

б) Сургалт явуулахдаа сурагч-төвтэй хандлага, идэвхжүүлэлт, өөрийгөө хүндлэх үзэл болон үнэ цэнэ, зан үйлийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн сэтгэл санааны хөгжлийг авч үзсэн, оролцооны, харилцан идэвхтэй, хамтын болон туршлага, практикт суурилсан арга зүйг ашиглан хүний эрхийн боловсрол дахь сургалтын зохих арга зүйг боловсруулах, мөн соёлын асуудлыг харгалзан үзэх, онолыг практиктай

холбох, сурч мэдсэн техникийг ажлын байр, анги танхимд туршиж үзэх, ашиглах.

в) Зохих сургалтын эх сурвалж, материалыг боловсруулах, нэвтрүүлэх хүрээнд хүний эрхийн боловсролын сургалтын сайн туршлагыг түүвэрлэх, түгээх, харилцан туршлага солилцох; ТББ-ууд болон иргэний нийгмийн бусад салбараас боловсруулсан сургалтын багшлах арга зүйг дахин нягталж, нэвтрүүлэх; цахим материал болон эх сурвалжуудыг боловсруулах.

г) Боловсролын болон сургалт явуулдаг янз бүрийн байгууллагуудын сүлжээ тогтоож хамтын ажиллагаа явуулах; олон улсын боловсрол, сургалтын үйл ажиллагаа болон солилцооны хөтөлбөрт оролцох, хөхиүлэн дэмжих.

д) Суралцагчын өөрийгөө-үнэлэх болон сургалтын холбоо хамаарал, хэрэглэгдэхүүн, үр нөлөөг хүлээж авсан талаарх сургалтын үйл ажиллагааг үнэлэх зэрэг орно.

Энэхүү төлөвлөгөөг Засгийн газрын холбогдох яамд, төрийн захиргааны байгууллагуудтай хамтарч ажиллаж буй боловсролын асуудал эрхэлсэн яам хэрэгжүүлэх гол үүрэгтэй бөгөөд дээд боловсролын байгууллагууд болон холбогдох сургалтын коллеж нь тухайн байгууллагын хараат бус байдлаас хамааран үүрэг хариуцлага нь харилцан адилгүй байх юм. Засгийн газар болон боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дараах байгууллагуудтай нягт хамтран ажиллахыг ХЭБДХ онцолсон байна. Үүнд: дээд боловсрол олгох багш нарын холбоо, оюутны холбоо, нийгэмлэг, хүний эрх/боловсролын асуудал хариуцсан парламентын хороод болон зөвлөх бүлгүүд, ХЭҮБ, UNITWIN Networks and UNESCO Chairs <sup>20</sup> хөтөлбөрүүдэд оролцдог дээд боловсролын холбогдох институтууд, үндэсний коллеж болон их сургуулиудын сүлжээ, ЮНЕСКО-гийн Үндэсний Комисс, боловсролын судалгааны хүрээлэнгүүд, үндэсний болон орон нутгийн хүний эрхийн сургалт, мэдээллийн төвүүд, тухайлан , дээд боловсролын хүрээлэнгүүд, дээд боловсрол олгох боловсон хүчин бэлтгэх сургалтын коллеж, төрийн бус байгууллагууд зэргийг оруулжээ. Түүнчлэн хэвлэл мэдээлэл, шашны байгууллагууд, орон нутгийн иргэдийн байгууллага, нутгийн уугуул иргэд болон үндэстний цөөнх, хувийн хэвшлийнхэн үүнд оролцож болно.

---

<sup>20</sup> UNITWIN нь их сургууль хоорондын мэдлэг чадвар дамжуулах, дэлхий даяар академик нийтлэг эрх ашгийг хөхиүлэн дэмжих явдлыг онцлохын сацуу их сургууль хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой 1992 онд байгуулагджээ.

### 1.3. Монгол Улс дахь хүний эрхийн боловсролын төлөв байдал

Манай улсын хувьд 1990 онд өрнөсөн ардчилсан хувьсгал, 1992 онд баталсан Үндсэн Хуулиас улбаалан хүний эрх, эрх чөлөө цоо шинэ утга агуулгаар баяжиж, түүнийг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн томъёолж, хангаж, хамгаалах эхлэл тавигдсан билээ. Улмаар хүний эрхийн боловсролыг бүх нийтэд, тодорхой зорилтот бүлэгт хүргэх явдал манай улсын тулгамдсан зорилтын нэг болоод байна. Хэдийгээр хүний эрхийн салбарт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс (2001)-ыг байгуулж, Монгол Улсад Хүний эрхийг хангах Үндэсний Хөтөлбөр<sup>21</sup> (ХЭХҮХ. 2003)-ийг баталсан зэрэг ололт амжилт багагүй байгаа ч хүний эрхийн боловсролыг албан боловсролын хөтөлбөрт, тэр дундаа эрх зүйчдийг бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгах талаар олсон амжилтаа бататгах, үнэлэх, цаашид сайжруулах талаар дүгнэн хэлэлцэх шаардлага тулгарч байна.

Монгол Улсын Засгийн газар нь хүний эрхийн гол зарчмуудын тухай Монгол Улсын Үндсэн Хууль болон түүний удиртгал хэсэгт дурдсан байна. Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 14-19 дүгээр зүйлүүдэд хүний эрх, эрх чөлөөний тухай тусгасан. Монгол Улсын Улсын Их Хурлаас 1995 онд баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д зааснаар Боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэхдээ Монгол орны эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн хөгжил, хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгаа, нутаг дэвсгэрийн бодлого, судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, олон нийтийн санал, хүсэлт, өөрийн орны онцлог, олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлага, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөл, боломж зэргийг харгалзан үздэг.

Боловсролын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зааснаар боловсролын стандарт нь суралцагчийн зайлшгүй эзэмшсэн байвал зохих боловсролын агуулгын түвшин, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлдог. Дээд боловсролын тухай хуулиар дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэхийг тодорхой заасан байдаг.

Монгол Улсын хувьд хүний эрхийн боловсролын талаар хийсэн нэгэн томоохон алхам нь 2003 оны 10-р сарын 23-ны өдөр Улсын Их Хурлын 43 дугаар тогтоолоор ХЭХҮХ-ийг баталсан явдал юм. Үүнд Монгол Улс нь нийт 30 гаруй хүний эрхийн гэрээ, конвенцид нэгдэн орсныг дурдаж, хөтөлбөрийн гол зорилго болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагыг доорх байдлаар тайлбарласан байна. Үүнд: Боловсролын тогтолцоо, сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгож, иргэдийн ерөнхий боловсролын болон эрх зүйн мэдлэгийн түвшинг цаашид дээшлүүлэн эрхээ эдлэх,

<sup>21</sup> <http://www.legalinfo.mn/annex/details/3225?lawid=6265>

хамгаалах чадвар эзэмшүүлэхэд чиглүүлэх шаардлага тавигдаж байна. ХЭХҮХ-ийн 1.1.2.6-д “Хүний эрхийн боловсролын төлөв байдал, хэрэгцээ шаардлага, хамрах хүрээг судалсны үндсэн дээр хүн ам, төрийн албан хаагчид, удирдах ажилтан, бүх шатны сургуулийн сурагч, оюутны хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцоог бүрдүүлж, энэ асуудлаар үндэсний мэргэжилтэн, сургагчдыг бэлтгэх дэд хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.” гэж заажээ. ХЭХҮХ нь ХЭҮК-ын хүлээх үүрэг хариуцлага (1.1.3.2), төрийн бус байгууллагуудын үүрэг (1.1.5), тодорхой хүний эрхтэй холбоотой асуудлыг (2.1-2.4) тус тус агуулсан байна. Иймд Засгийн газрын хүний эрхийн боловсролыг дэмжихэд чиглэсэн тодорхой эрх, хэм хэмжээ бүрдсэн гэж үзэж болно.

Улмаар Засгийн газрын 2007 оны 17 дугаар тогтоолоор “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2007-2008 оны төлөвлөгөө”-г баталж, хүний эрхийн албан ба албан бус сургалтын тогтолцооны загвар боловсруулж, хүний эрхийн мэргэшсэн сургагч багш нарыг бэлтгэх дэд хөтөлбөр боловсруулж ажиллахыг тухайн үеийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд даалган ажиллажээ. Гэвч энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал тодорхойгүй бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилтийг хэрхэн үнэлж, дүгнэсэн талаарх мэдээллийг гаргаагүй байна.

Монгол Улсын Засгийн газар 2006-2015 онд хэрэгжүүлэх Боловсролын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө (БСХМТ)-г боловсруулж, уг төлөвлөгөөнд хүний эрхийн боловсролын асуудлыг өргөн хүрээнд авч үзсэн байна. Үүнд: эмзэг бүлэг, сургуульд хамрагдалт, малчин хүүхдийн асуудал, сургуулийн дотуур байр, сургуулийн орчин, жендер, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, тэгш бус байдал, мэдээлэл технологийн хөгжил, эрүүл мэнд болон эрүүл ахуй зэрэг болно. Ялангуяа дунд хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөөний 4-р бүлэгт:

- 4.1-д Бага насны хүүхдийн боловсрол,
- 4.2-д Суурь болон дунд боловсрол,
- 4.3-д Албан бус болон насанд хүрэгчдийн боловсрол,
- 4.4-д Мэргэжлийн баримжаа олгох сургалт буюу техникийн боловсрол,
- 4.5-д дээд боловсролтой холбоотой асуудал, зорилго зорилтуудыг тодорхойлжээ.

Дээд боловсролын агуулга нь суралцагчдад шинжлэх ухаан, техник, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, иргэний ухамсар, хүмүүжил төлөвшүүлэхэд чиглэдэг. Монгол Улс дахь дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрийн агуулга нь өөр өөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэдэг. Ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх, мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол- арга зүйн мэдлэг эзэмшүүлэх, мэргэших хэсгийн агуулга

нь суралцагчид нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тухайн мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэж байна.

Их, дээд сургуулийн хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг хэрхэн тусгасан талаар цөөн тооны судалгааны ажлууд байдаг. Гэвч төрийн болон хувийн хэвшилд ажиллаж байгаа албан хаагчдын зүгээс хүний эрх, эрх чөлөөг зөрчих явдал түгээмэл байгааг хүний эрхийн хэрэгжилтийн судалгааны үр дүн харуулж байна. Тиймээс “Хүний эрх” хичээлийг дээд боловсролын сургалтын нэгэн судлагдахуун болгон оруулах замаар мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтад оруулах шаардлагатай юм.

Эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудын хувьд 1997 онд Монгол Улсын Гэгээрлийн сайд, Хууль зүйн сайдын 239/200 дугаар хамтарсан тушаалаар “Хууль зүйн сургалт явуулдаг сургуулиудад мэргэжлийн чиглэлээр заавал үзэх хичээлийн жагсаалт”-ыг баталсан бөгөөд уг жагсаалтад “Хүний эрх” хичээлийг 36 цагийн багтаамжтайгаар багтаасан нь чухал алхам болсон билээ.

Улмаар уг жагсаалтын дагуух сургалтын үйл ажиллагаа 1997 оноос хэрэгжиж эхэлсэн боловч бодит байдал дээр цөөн тооны сургууль хүний эрхийн хичээлийг заавал үзэх, ихэнх сургуулиуд сонгон суралцах байдлаар үзэхээр заасан байв. Энэ нь эрх зүйч, хуульч мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын хувьд зохистой хандлага биш байсан бөгөөд зарим сургуулийн удирдлагуудын зүгээс хүний эрхийн хичээлийг бусад салбар эрх зүйн хүрээнд ярих боломжтой, тусгайлан үзэх шаардлагагүй гэж татгалзсан тохиолдол тухайн үеийн судалгааны тайланд тусгагдсан байдаг. Улмаар 2001 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 91/91 тоот тушаал<sup>1</sup>-аар “Эрх зүйн бакалаврын зэрэг олгох сургалтын агуулгын үндэсний стандартыг туршилтын журмаар баталж, заавал үзэх мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтаас хүний эрх хичээлийг хассан нь хүний эрхийн боловсролын салбарт гарсан ухралт болсон гэж хэлж болно.

Бусад их дээд сургуулиудын хувьд эрх зүйн хичээлийн цагт хүний эрхийн хичээлийг судалдаг гэх ч энэ нь Үндсэн хуулийн эрх зүйн хичээлийн хүрээнд орж байгаагаас тухайн мэргэжилтэй холбоотой хүний эрхийн тухай асуудлыг дэлгэрүүлэн заадаг сургууль ховор байна. Түүнээс гадна хүний эрхийн асуудал бол зөвхөн хуульч мэргэжилтэн мэдвэл зохих зүйл гэж хэт өрөөсгөл хандах явдал манай улсын их дээд сургуулийн удирдлага, багш, оюутнуудын дунд байсаар байгаа юм.

Мэргэшсэн байгууллага болохын хувьд ХЭҮК-ын нэг үндсэн чиг үүрэг нь хүний эрхийн боловсролыг хөхүүлэн дэмжих явдал юм. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5-д “Хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих” гэж эрх зүйн үндсийг тодорхойлсон ба ХЭҮК-ын Стратеги төлөвлөгөөний 1.2-д “Холбогдох яам, газруудтай хамтарч дунд сургууль, их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, мэдээлэл түгээх, сурталчилгаа хийх иж бүрэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх” гэж оруулжээ.

ХЭҮК-ын үе үеийн стратеги төлөвлөгөөнд хүний эрхийн боловсролыг хөхиүлэн дэмжих чиг үүрэг нь түүний үйл ажиллагааны үндсэн хэсэг гэж заасан



байдаг. Тухайлбал, ХЭҮК-ын 2004-2006 оны Стратеги төлөвлөгөөнд тусгасны дагуу байгууллагын зорилго-1-д “Иргэд эрх, эрх чөлөөгөө сайтар мэдэж, эрхийн төлөө чадвартай болгохын тулд хүний эрхийн мэдлэг, соёл, ухамсрыг дээшлүүлэх<sup>22</sup>” гэж тодорхойлжээ.<sup>23</sup> 2007-2011 онд хэрэгжүүлэх ХЭҮК-ын Стратеги төлөвлөгөөнд хүний эрхийг дэмжих, хамгаалах чиглэлээр ерөнхий буюу тодорхой стратеги төлөвлөгөөг тусгажээ. Уг баримт бичгийн 3-р зорилтод зааснаар “Боловсролын бүх шатанд хүний эрхийн сургалтын хүрээг сайжруулах, бий болгох, өргөтгөх” гэсэн нь хүний эрхийн боловсролыг олгох хэрэгцээ шаардлага байгааг тодорхой харуулсан байна. Комиссын Хүний эрхийн боловсролын хөтөлбөрийн эрхэм зорилго нь хүний эрхийн үзэл баримтлалыг нийгмийн хэм хэмжээ, үйл байдал бүрт шингээхэд чиглэгдсэн бөгөөд хөтөлбөр нь:

- Бүх шатны сургуульд
- Нийгмийн тодорхой зорилтот бүлэгт
- Иргэд, олон нийтэд гэсэн гурван үндсэн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн байдаг.

Иймд ХЭҮК-ын зүгээс холбогдох яам, газруудтай хамтарч ерөнхий боловсролын сургууль, их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгох, хүний эрхийн сургалт явуулах нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

ХЭҮК-оос албан боловсролын хөтөлбөрт хүний эрхийн боловсролыг тусгуулахаар хийсэн нэг чухал ажил бол Канад сангийн дэмжлэгтэйгээр 2003 онд хэрэгжүүлсэн “Хүний эрхийн боловсрол” төсөл билээ. Энэ төслийн хүрээнд эрх зүйн боловсрол олгож буй их дээд сургуулийн хүний эрхийн хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулсан юм. Хүний эрх, эрх чөлөөг цоо шинэ утга агуулгаар баталгаажуулсан өнөөгийн нийгэмд хүний эрхийн боловсролтой, асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй ханддаг эрх зүйч мэргэжилтэнг бэлтгэн гаргах нь нэн тулгамдсан асуудал болж байна. Учир нь хууль, шүүхийн байгууллага нь хүнийг мөрдөх, шийтгэх зэвсэг, төрийн илд гэж үзэх нийгмийн хандлага өнөөг хүртэл байсаар байгаа, хууль сахиулах ажиллагаанд хүний эрхийн зөрчлүүд гарсаар байгаа нь ХЭҮК болон бусад байгууллагуудын явуулсан судалгаагаар тогтоогдсон. Тухайн үед хуульч мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудад судлах хүний эрхийн хичээлийн хөтөлбөрийн зорилгыг “хүний эрхийн талаар өндөр мэдлэг, хүний эрхийг хангах, хамгаалах арга, механизмыг ашиглах чадвар, хүний эрхийг эрхэмлэн хүндэтгэх хандлага бүхий цогц чадамжийг оюутанд төлөвшүүлэх явдал” гэж тодорхойлсон байна.

Уг ажлын хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Шихихутуг” Хууль зүйн сургууль, “Билиг” Хууль зүйн сургуулиуд хүний эрхийн клиник сургалтын төвүүдийг нээн ажиллуулж, тэдгээр сургуулийн багш, оюутнуудыг үе шаттайгаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан байна. Эдгээр сургалтын үр дүнд үндэслэн нийт хуулийн их дээд сургуулиудад үзэх “Хүний эрх” хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулан, тэдгээр сургуулиудтай хамтран ажиллажээ. Энэхүү загвар хөтөлбөр нь эрх зүйч мэргэжилтэн

<sup>22</sup> ХЭҮК (2005) Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2005 Улаанбаатар, х.57

<sup>23</sup> ХЭҮК (2005) Монгол улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2005 Улаанбаатар, х.74

бэлтгэдэг сургуулиудын төгсөх ангид 2 кредит (48 цаг) цагийн хүрээнд хүний эрхийн онол болон практикийн зохистой харьцааг тогтоох, хүний эрхийг хангах, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх садвар, дадлыг хөгжүүлэхэд чиглэсэн агуулга, арга зүй бүхий байдлаар боловсруулсан болно.



Тус төслийн хүрээнд боловсруулсан загвар хөтөлбөр нь нилээд иж бүрэн шинжтэй болсон ба хөтөлбөрт тусгасан хичээлүүдийг заахад баримтлах оролцооны аргуудыг санал болгосон. Түүнчлэн багшийн онолын мэдлэгт хувь нэмэр болох мэдээллийн болон түгээмэл хэрэглэгддэг арга зүйг хэрэглэх аргачлалуудыг багтаасан хоёр хавсралтаас бүрдсэн байна. Энэ хөтөлбөрийг сайжруулах үүднээс гурван их дээд сургуульд туршилт хийж, 20 оюутныг оролцуулсан зуны сургалт зохион байгуулсан байна. Улмаар ХЭҮК оюутнуудад зориулсан хүний эрхийн зуны сургалтыг 2003-2005 онуудад, мөн 2013 онд тус тус зохион байгуулсан болно. Уг сургалт нь оюутнуудад хүний эрхийн мэдлэг олгох, аливаа асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй хандах хандлага төлөвшүүлэх, хүний эрхийг хамгаалах ур чадвар эзэмшүүлэхэд чиглэдэг юм.



Хөтөлбөрийн зэрэгцээ хууль зүйн сургуулиудад суралцаж буй оюутнуудыг клиник сургалтад хамруулж, практик дадал, чадвар эзэмшүүлэх, хүний эрхийн мэдрэмжтэй, чадварлаг хуульч бэлтгэн гаргах зорилгоор “Хууль зүйн зөвлөгөө өгөх төв”-ийг байгуулан 2004-2005 онд ажиллуулсан байна. Энэ үйл ажиллагаанд МУИС-ийн Хууль зүйн сургууль, “Шихихутуг” Хууль зүйн сургууль, “Билиг” Хууль зүйн сургуулийн клиник сургалтын төвүүд хамтран ажиллажээ. Мөн ХЭҮК энэ чиглэлээр Цагдаагийн академитай хамтын ажиллагаа тогтоож, 2005 онд тус академид сургалтын иж бүрэн тоноглол, хэрэгсэл бүхий “Хүний эрхийн сургалтын төв”-ийг байгуулан хүлээлгэж өгсөн байна. Тус Академийн зүгээс үйл ажиллагааны төлөвлөгөө гарган, сонсогч нарын дунд сургалтууд зохион байгуулах үүрэг хүлээсэн байна. Төслийн хүрээнд 20 орчим их дээд сургуулийн 60 гаруй багш нарт (давхардсан тоогоор) хөтөлбөрөөр хэрхэн хичээл заах тухай арга зүйн сургалтыг 3 удаа, мөн хүний эрхийн хичээлийг заавал судлахын ач холбогдлыг дүгнэн хэлэлцсэн бага хурал зэрэг олон тооны сургалт, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулсан байна.

Дээд боловсролын салбар дахь хүний эрхийн боловсролд зайлшгүй шаардлагатай нэгэн салбар бол багш бэлтгэх, давтан бэлтгэх сургуулиуд юм. Монгол Улс дахь багш бэлтгэх хамгийн том тогтолцоо бол Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС) юм. Энэ чиглэлээр тус их сургуулийн эрх зүй, нийгмийн ухаан, түүхийн багшийн ангид “Хүний эрхийн боловсрол” хичээлийн хөтөлбөрийг сонгон суралцах хичээлийн хүрээнд судлаж байгаа нь томоохон ахиц дэвшил болсон билээ.

МУБИС нь өөрийн дэргэд “Хүний эрхийн боловсролын төв”-ийг 2006 оноос нээн ажиллуулж, бүх шатны сургалтаар хүний эрхийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтад нэвтрүүлэх, тэдгээрийг заах багш нарыг бэлтгэх, давтан бэлтгэх зорилго тавин ажиллаж байв. Энэхүү зорилгын хүрээнд “Хүний эрхийн боловсрол” шинэ хичээлийн хөтөлбөр боловсруулан 2 кредит бүхий 48 цагийн багтаамж агуулгатайгаар боловсруулж багш бэлтгэх тогтолцоонд нэвтрүүлсэн байна. Уг хөтөлбөрийг хүний эрхийг заан сургах цогц чадамж олгоход чиглэсэн 1-8 модуль бүхий агуулгатайгаар боловсруулсан байна. Мөн хүний эрхийн боловсролын багш, оюутны гарын авлага, сургалтын материал мэдээлэл-сургалтын интернэт хуудас зэргийг боловсруулан ажиллаж байна. Дээр дурдсан ажлууд нь Комиссын зүгээс хүний эрхийн боловсролыг албан боловсролын хөтөлбөрт оруулахад хувь нэмэр болоход чиглэсэн ба цаашид ч энэ чиглэлийн үйл ажиллагаагаа улам бүр эрчимжүүлэн ажиллаж байна.

2007 онд “Эрх зүйн боловсролын бакалаврын стандарт”<sup>24</sup> <sup>25</sup> -ыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2007 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 36 дугаар тогтоолоор баталсан ба 2008 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна. Уг стандартад “Эрх зүйн боловсролын бакалаврын стандартын зорилго нь эрх зүйн бакалаврын боловсролын агуулга, үнэлгээ, сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг баталгаажуулж, дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааны бие даасан байдлыг дэмжих, сургалт олон хувилбартай байх нөхцлийг

<sup>24</sup> <http://estandard.mn/file.php?sid=4007>

<sup>25</sup> [http://moj.gov.mn/index.php?option=com\\_content&view=article&id=152%3Astandart&Itemid=164](http://moj.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=152%3Astandart&Itemid=164)

бүрдүүлэхэд оршино.” гэж заасан байна. Уг стандартын 5 дугаар зүйлийн 5.3.3-т зааснаар “Төгсөгчдөд дараахь хандлага төлөвшсөн байна.”

5.3.3.1-д “Хувь хүний болон иргэний эрх, эрх чөлөө, ардчилсан ёс, хууль дээдлэх зарчим, шударга ёсыг эрхэмлэдэг;”

5.3.3.2-т “Хуульчийн мэргэжлийн ёс зүйг сахин биелүүлдэг болно” гэж заажээ.

Стандартад мэргэжлийн суурь хичээлүүдийг жагсаасан ба үүнд хүний эрхийн бие даасан хичээлийг оруулаагүй байна. Харин 2 багц цаг бүхий “Олон улсын нийтийн эрх зүй” хичээлийн агуулгад хүний эрхийг багтаажээ.

БШУЯ-ны боловсруулсан “Дээд боловсролын шинэчлэлийн зураглал 2010-2021”<sup>26</sup>-д дурдсанаар одоогоор манай улсын дээд боловсролын салбарт дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- Дээд боловсролын сургалтын чанар, нийлүүлэлт нь суралцагч, ажил олгогч, олон нийтийн эрэлтэд тохирохгүй байна. Ялангуяа төгсөгчдийн мэргэжлийн төвшин, ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахгүй байна.
- Мэдлэгийн хүрээг тэлэх, технологийн хөгжлийг хөтлөх үүрэгтэй их сургуулийн систем бүрдэж чадаагүй байна.
- Дээд боловсролын салбарын эрх зүйн орчинг сайжруулах, санхүүжилтын тогтолцоог шинэчлэх шаардлагатай.
- Сургалт, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн байгууллагуудын уялдаа холбоо, түншлэл хангалтгүй байна.
- Дээд боловсролын сургалт, судалгаа зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдахгүй байна.
- Дээд боловсролын сургалтын байгууллагуудын удирдлагын арга барил, менежментийн ур чадвар дутагдалтай, багш нарын цалин бага, хөдөлмөрийн зах зээл дээрх үнэлэмж доогуур байна.

Тиймээс дээд боловсролын байгууллагуудын сургалт, судалгааны ажлын стандартыг шинэчлэх шаардлагатай, чанарын баталгаажуулалтын тогтолцоог үр дүнтэй ажиллуулах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрчээ. Мөн хичээлийн байр, сургуулийн дэд бүтэц, судалгааны лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн, мэдээлэл харилцааны технологи, номын санд хөрөнгө оруулалт дутагдалтай байгааг онцолжээ.

Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчлөөс урьдчилан сэргийлэх болон хүний эрхийн боловсролыг нийгмийн бүхий л бүлгүүдэд олгоход чиглэсэн бодлого, мэдээлэл сургалтын үйл ажиллагаа зохион байгуулдаггүйн улмаас ард иргэдийн дунд болон нийгэмд хүний эрхийн соёл хараахан төлөвшиж амжаагүй байна. Үүний гол учир шалтгаан нь хүний эрхийн боловсролын албан ба албан бус сургалтын үйл ажиллагаа системчлэгдээгүй, үр дүн муутай зэргээс хамаарч байна. Нөгөө талаас төрийн болон төрийн бус байгууллагууд, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн оролцоо, үүсгэл санаачлагууд мөн дутагдалтай байна. Эдгээр нь хүний эрхийн боловсролыг

<sup>26</sup> <http://www.meds.gov.mn/Дээд-боловсролын> шинэчлэлийн зураглал

дээд буюу мэргэжлийн боловсролын бүрэлдэхүүн хэсэг болгон оруулах зайлшгүй шаардлагатай болохыг харуулж байна.

Дээд боловсролын шинэчлэлийн хүрээнд дээд боловсролын байгууллагын бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг баталсан бөгөөд мөн БШУ-ы Сайд 2014 оны 6 сард А/285 дугаар тушаал гарган, бакалаврын ерөнхий суурь чиглэлийн заавал судлах хичээлийн жагсаалтыг шинэчлэн баталжээ. Бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь чиглэлийн заавал судлах хичээлийн жагсаалтад дараах хичээлүүд багтжээ.

Хичээлийн нэр	Эзэмших чадвар	Багц цаг
<b>Монголын түүх, соёл, ёс заншил (иргэний боловсрол)</b>	Монголын түүхийн үндсэн сурвалж бичгүүдийг (3-аас цөөнгүй) тоймлон дүгнэж, хөгжилд нөлөөлсөн дотоод, гадаад хүчин зүйлсийн талаар шүүмжит дүгнэлт хийх, түүнийгээ нотлон мэтгэлцэх чадвартай болно.	3
<b>Монгол хэл бичиг, найруулга зүй (яриа бичгийн ур чадвар)</b>	Эх хэлээрээ логик дэс дараалалтай, үндэслэлтэй, товч тодорхой, үнэн зөв амаар болон бичгээр өөрийгөө илэрхийлэх чадвартай болно. Эрдэм шинжилгээний бичвэр үйлдэх, түүнд дүн шинжилгээ хийх чадвар эзэмшинэ.	3
<b>Хүний хөгжил, харилцааны ёс зүй, эрх зүй (хүмүүнлэгийн ухаан)</b>	Хүний үндсэн эрх, хувь хүний төлөвшил, хөгжлийн талаар суралцах, бүтээлч сэтгэлгээ, хувийн зохион байгуулалт, өөрийгөө хянах чадвар, багаар ажиллах чадвар, нийгэм, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд биечлэн оролцох, зохион байгуулах чадвар эзэмшинэ.	3
<b>Сэтгэлгээний түүх, соёл (хүмүүнлэгийн ухаан)</b>	Сэтгэлгээний түүхийг танин мэдэх, философи, философийн үндсэн урсгалууд, тэдгээрийн оюун сэтгэлгээнд үзүүлэх нөлөөг танин мэдэж, цаашид оюунлаг дүгнэлт хийх философи сэтгэлгээний үндсийг эзэмшинэ.	3

Дээрх хичээлүүдийг ерөнхий суурь чиглэлийн заавал судлах хичээл болгон судалснаар хүний эрх, эрх чөлөөний тухай ерөнхий ойлголт эзэмших мэргэжлийн чиг баримжаанаас үл хамааран бакалаврын боловсрол эзэмшиж буй хүн бүрт хүрэх боломжтой болсон нь дэвшилтэт алхам болжээ. Гэвч энэ нь бакалаврын ерөнхий эрдмийн суурь хичээлийн хүрээнд хүний эрхийн анхан шатны ойлголт өгөх байдлаар хэрэгжих тул эрх зүйч, багш, нийгмийн ажилтан, эмнэлгийн ажилтан зэрэг мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын хөтөлбөрт хүний эрхийн хичээлийг гүнзгийрүүлэн судлах, төрийн албан хаагчдад тавих мэргэжлийн шалгуурт оруулах, төрийн албаны шалгалтын агуулгад тусгах зэргээр олон төрлийн арга үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлбэл зохистой байна. Хууль, эрх зүйн онол, практикийн асуудлуудад хүний эрхийн үзэл баримтлал гүнзгий туссан байдаг тул хүний эрхийг судлах, тодорхой сургалтын арга хэлбэрүүдээр дамжуулан оюутан суралцагчдад цогц мэдлэг чадвар олгоход тусгайлан анхаарах шаардлагатай. Тиймээс эрх зүйн боловсрол олгож байгаа их дээд сургуулийн боловсролын стандартыг шинэчлэх, хүний эрхийн хичээлийг заавал үзэх судлагдахуун болгох, түүний сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх талаар зохих байгууллагууд анхааран ажиллах шаардлагатай байна.

БШУЯ-аас “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ын шинэчлэн найруулсан төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан бөгөөд үүнд боловсролын салбарт урт хугацаанд тогтвортой баримтлах бодлого, стратегийг тодорхойлж, төрөөс боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхээр тусгажээ. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого шинэчлэн батлагдсанаар боловсролын чанарын баталгааг хангах, олон улсын түвшинд өрсөлдөх чадвар бүхий боловсролын үйлчилгээг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх үүднээс боловсролын салбарын дараах хууль тогтоомжид зохих өөрчлөлтүүд орох юм байна. Ингэснээр Боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай, Бага, дунд боловсролын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай зэрэг хуулиудад өөрчлөлт орох юм. Иймд “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-ыг шинэчлэх, хэлэлцэх энэ үед хүний эрхийн боловсролыг дэмжих, дээр дурдсан эрх зүйч, багш зэрэг мэргэжилтнийг бэлтгэх сургалтын хөтөлбөрт тусгах зэрэг асуудлыг бодлогын баримт бичигт тусгайлан тусгах шаардлагатай гэж үзэж байна.

# ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН ИХ, ДЭЭД СУРГУУЛИУДАД “ХҮНИЙ ЭРХ” ХИЧЭЭЛИЙГ ЗААЖ БУЙ НЬ

## 2.1. Хууль зүйн их, дээд сургуулиудын “Хүний эрх” хичээл

Эрх зүйн боловсрол олгож буй сургуулиудад хүний эрхийн сургалтыг зөвхөн лекц хэлбэрээр, хүний эрхийн онол заах явдлаар хязгаарлах явдал байгааг Комисс өмнө хийсэн судалгаагаараа онцолж байсан билээ<sup>27</sup>.

Түүнчлэн зарим сургуулиудын хувьд энэ хичээлийг сонгон суралцах хичээл болгосноор бүх оюутнуудын сонирхдог сэдэв болж чадахгүйд хүргэж байгааг шүүмжилсэн юм. Хуулийн мэргэжлийн сургалтын нийт хөтөлбөр нь хүний эрхийн хамгаалалтад бүхэлдээ чиглэх ёстойг анхаарахын зэрэгцээ хуульчид өөрсдөө хүний эрхийг хамгаалагч, болзошгүй зөрчигч байдаг хоёрдмол байдлыг анхаарч илүү мэргэжлийн бөгөөд хэрэглээний шинжтэй сургалтын хөтөлбөр боловсруулах шаардлагатай байгааг анхааруулж байв<sup>28</sup>.

Комисс 2003 онд Канад сангийн санхүүжилтээр эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулийн “Хүний эрх” хичээлийн загвар хөтөлбөрийг боловсруулах, тухайн хичээлийг заадаг багшлах боловсон хүчнийг бэлтгэх төслийг хэрэгжүүлж байв. Төслийн хүрээнд “Хүний эрх” хичээлийн хөтөлбөр агуулгыг шинэчлэн боловсруулах зорилгоор эрх зүйн боловсрол олгодог их, дээд сургуулийн хүний эрх хичээл заадаг 5 багш, сургалтын орчин үеийн арга барилыг эзэмшсэн 2 багшаас бүрдсэн багийг байгуулан ажиллуулсан ба Канадын Хүний эрхийн сангаас зохион байгуулдаг Хүний эрхийн Олон улсын сургалтад 2002 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгээр оролцсон Комиссын төлөөлөгч төслийн багийн үйл ажиллагааг зохицуулж ажилласан юм<sup>29</sup>. Шинээр боловсруулсан загвар хөтөлбөр нь 16 цагийн лекц, 32 цагийн семинарын цагийн хуваарилалттай байв.

Үүнээс өмнө Комисс 2002 оны 10 дугаар сарын 30-нд эрх зүйн боловсрол олгодог 12 их, дээд сургуулийн багш нарыг оролцуулсан нэг өдрийн сургалт, семинарын үеэр энэ хичээлийн хөтөлбөр, агуулгыг хэрхэн сайжруулах талаар харилцан санал солилцож байжээ.

Хүний эрх хичээлийн загвар хөтөлбөрийн гол зорилго нь хүний эрхийн талаар өндөр мэдлэг, хүний эрхийг хангах, хамгаалах арга, механизмыг

<sup>27</sup>“Хүний эрхийн боловсрол” төслийн баримт бичиг. 2004 он. 1 дэх нүүр

<sup>28</sup>“Хүний эрхийн боловсрол” төслийн баримт бичиг. 2004 он. 1 дэх нүүр


<sup>29</sup>Загвар хөтөлбөрийг дараах бүрэлдэхүүнтэйгээр боловсруулж байв. Үүнд: ХЭҮК-ыг төлөөлж: ХЭҮК-ын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Ж.Дашдорж, ХЭҮК-ын ажлын албаны дарга Б.Хишигсайхан, ХЭҮК-ын референт Г.Золжаргал, Их, дээд сургуулиудыг төлөөлж: МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, профессор Д.Солонго, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн багш, дэд профессор, докторант Д.Дүгэржав, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Д.Ганзориг нар болон бусад багш нар.

ашиглах чадвар, хүний эрхийг эрхэмлэн хүндэтгэх хандлага бүхий цогц чадамжийг оюутанд төлөвшүүлэхэд оршиж байсныг судалгааны өмнөх бүлэгт дэлгэрэнгүй тайлбарласан билээ.

Энэ удаад Комисс эрх зүйн боловсрол олгож буй төрийн болон төрийн бус өмчийн дараах их, дээд сургуулиудад “Хүний эрх”, түүнтэй ижил төсөөтэй хичээлүүдийг хэрхэн орж байгааг харьцуулан судаллаа. Уг судалгаанд дараах сургуулиуд хамрагдав. Үүнд:


1. Их Засаг Олон Улсын Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль
2. МУИС-ийн Хууль Зүйн Сургууль
3. МҮИС-ийн Хууль Зүйн Удирдлагын Сургууль
4. Орхон Их Сургууль
5. Отгонтэнгэр Их Сургуулийн Хууль Зүйн Сургууль
6. Түшээ Дээд Сургууль
7. Улаанбаатар Их Сургууль
8. Үндэсний Тагнуулын Академи
9. Хууль Сахиулахын Их Сургууль
10. Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн Билэг Дээд Сургууль
11. Шихихутуг Хууль Зүйн Дээд Сургууль

Эрх зүйн боловсрол олгож буй сургуулиудыг байгуулагдсан он дарааллаар нь авч үзвэл:



Харин өмчийн хэлбэрийн хувьд Хууль сахиулахын их сургууль, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль, Үндэсний тагнуулийн академи гэсэн 3 сургуулиас бусад нь хувийн өмчийн сургуулиуд байна.





### 2.1.1. Их засаг олон улсын их сургуулийн Хууль зүйн сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** Их Засаг олон улсын их сургууль нь харъяа бүрэлдэхүүний 14 сургуультайгаар хоёр цогцолборт үйл ажиллагаагаа явуулж, 7000 оюутан суралцаж байна. Хууль зүйн сургууль нь 1994 онд Их Засаг Хууль Зүйн дээд сургууль нэртэй байгуулагдсан.

Хууль зүйн сургууль нь 1-р цогцолборт байрлан нэг ээлждээ 2000 оюутан суралцах хүчин чадал бүхий 4 давхар бие даасан хичээлийн байранд сургалтын үйл ажиллагаа явуулдаг. Хууль зүйн сургууль нь эрүүгийн эрх зүйн тэнхим, иргэний эрх зүйн тэнхим, төр захиргааны эрх зүйн тэнхим гэсэн 3 тэнхимтэй, багш нарын 92% нь магистр ба түүнээс дээш зэрэгтэй байна.

Хууль зүйн сургуулийн Хууль зүйн клиник сургалтын төв нь 2007 оноос эхлэн ажиллаж оюутнуудад онолын мэдлэг олгохоос гадна практик дадал чадвар эзэмшүүлэх сургалт зохион байгуулж, иргэдэд хууль эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, туслалцаа үзүүлж байна. Хууль зүйн сургууль нь дэргэдээ 500 оюутны дотуур байр, цайны газар, спорт цогцолбор, интернет номын сантай.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Хууль зүйн сургууль нь эрх зүйч (өдөр, эчнээ), иргэний аюулгүй байдал, бие хамгаалал мэргэжлийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг. Өнгөрсөн хугацаанд тус сургууль эрх зүйч мэргэжлээр 16 удаа төгсөлт хийж, нийт 5000 орчим бакалавр, 400 гаруй магистр төгссөн байна.

#### “Хүний эрх” хичээл

Анги: Бакалаврын 2-р дамжаа  
Судлах хэлбэр: Заавал судлах хичээл



Цаг: Лекц 24 цаг, семинар 16 цаг  
Багц цаг: 2  
Хичээлийн хөтөлбөр баталсан он: 2014

Тус сургуульд “Хүний эрх” бие даасан хичээл ордог. Хууль зүйн сургуулийн эрх зүйч мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд “Хүний эрх” хичээл нь эрх зүйн 2-р дамжаанд заавал судлах хичээлийн жагсаалтад багтдаг. Мөн эрх зүйн магистрын сургалтад “Хүний эрхийн хэрэгжилт” хичээл ордог.

Тус сургуульд “Хүний эрх” хичээлийг Төр, захиргааны эрх зүйн тэнхимд хамаарах 4 багш зааж байна. Багш нар нь магистрын зэрэгтэй, ахлах багш, багш, дадлагын багшийн зэрэглэлтэй ба 2-14 жил ажилласан туршлагатай байна. Төр, захиргааны эрх зүйн тэнхимээс олон улсын хүний эрхийн өдөрт зориулсан эссэ бичлэгийн уралдаан, шилдэг ханын сонин шалгаруулах уралдааныг жил тутам зохион байгуулдаг байна.

### 2.1.2. Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** Монгол Улсын Их Сургуульд хуулийн анги нээх тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн шийдвэр 1957 онд гарч, 1960 онд МУИС-ийн хууль зүйн анхны ангийнэлсэлтээ авсан байна. 1960 оноос МУИС-ийн Хэл, нийгмийн ухааны факультет, улмаар Нийгмийн ухааны факультетын бүрэлдэхүүнд хууль зүйн салбар болон үйл ажиллагаагаа явуулж байсан бол 1991 оноос МУИС-ийн Хууль зүйн факультет, 1994 оноос Хууль зүйн сургууль болон өргөжжээ.

Хууль зүйн сургууль нь бүтцийн хувьд Эрүүгийн эрх зүйн тэнхим, Иргэний эрх зүйн тэнхим, Төр, захиргааны эрх зүйн тэнхим, Эрх зүй судлалын тэнхим, Олон улсын эрх зүйн тэнхим, Практик сургалтын тэнхим гэсэн үндсэн зургаан тэнхимтэй бөгөөд Японы эрх зүйн боловсрол судалгааны төв, Солонгосын эрх зүйн боловсролын төв, Харьцуулсан эрх зүйн судалгааны төв гэсэн гурван төвтэй.

Сургуулийн багшлах боловсон хүчний тухайд үндсэн багш 36, зөвлөх профессор 2, гэрээт багш 8, нийт 46 багштай сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулж байна.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** МУИС-ийн Хууль зүйн сургууль нь дараах төрлийн сургалт явуулдаг:

- Бакалаврын сургалт (LL.B) - өдөр 5 жил, орой 2.5 жил, эчнээ 3.5 жил 120-150 багц цаг
- Магистрантурын сургалт (LL.M) - өдөр 2 жил, эчнээ 3 жил
- Докторантурын сургалт (Ph.D) - өдөр 3 жил, эчнээ 4 жил

2013-2014 оны хичээлийн жилд бакалаврын түвшинд өдрийн ангид 786 оюутан (эрх зүй - 692, олон улсын эрх зүй - 94), их дээдийн оройн ангид 119 оюутан, их дээдийн эчнээ ангид 154 оюутан суралцаж байна. Харин ахисан түвшинд буюу магистрантурт 340, докторантурт 65 оюутан суралцаж байна.

## “Хүний эрх” хичээл

Анги: Бакалаврын 4-р дамжаа  
Судлах хэлбэр: Сонгон судлах хичээл  
Цаг: Лекц 24 цаг, семинар 16 цаг  
Багц цаг: 2  
Хичээлийн хөтөлбөр баталсан он: 2012

“Хүний эрх”, “Хүүхдийн эрх хамгаалал”, “Эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаан дахь хүний эрхийн баталгаа” зэрэг хичээлүүд нь сонгон судлах хичээлүүд тул тухайн семестрт оюутнууд сонгосон эсэхээс хамааран хичээл судалдаг.

“Хүний эрх”, түүнтэй ижил төсөөтэй хичээлүүдийг бакалаврын түвшинд Төр, захиргааны эрх зүйн тэнхимийн багш нар заахаас гадна бусад салбар эрх зүйн багш нар хичээлийн сэдэвтэйгээ холбогдуулан зааж байна. Харин магистр, докторын сургалтын түвшинд Төр, захиргааны эрх зүйн тэнхим, Эрүүгийн эрх зүйн тэнхимийн багш нар хүний эрхийн чиглэлээр хичээл ордог.

Сүүлийн 5 жилийн хугацаанд оюутнууд дээрх хичээлүүдийг сонгон судлаагүй байна.

**Бусад сургалт, үйл ажиллагаа:** “Хүний эрх”, түүнтэй ижил төсөөтэй хичээлүүд болох “Үндсэн хуулийн эрх зүй”, “Хүүхдийн эрх хамгаалал”, “Эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагаан дахь хүний эрхийн баталгаа” зэрэг хичээлүүд сургалтын төлөвлөгөөнд багтдаг. Дээр дурдсан “Үндсэн хуулийн эрх зүй” хичээл нь заавал судлах үндсэн хичээл бөгөөд жилд дунджаар өдөр, их дээд, эчнээ ангийн нийлсэн 200 орчим оюутан судалж байна.

Хууль зүйн сургууль 2008-2009 онд НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал” төслийг хэрэгжүүлсэн байна. Төслийн үр дүнд “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал” гарын авлага боловсруулж гаргажээ. 2013 оны 12 дугаар сард Хүний эрхийн өдрийг тохиолдуулан Монгол Улс дахь “Эмнести Интернэйшнл” байгууллага, ХЭҮК-той хамтран “Хэний эрхийн боловсролын боловсролын тогтолцоонд” онол практикийн бага хурлыг зохион байгуулж байсан.

### 2.1.3. Монголын Үндэсний Их Сургуулийн Хууль зүйн удирдлагын сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** Монголын Үндэсний Их Сургууль анх Гэгээрлийн сайдын 1998 оны 7 сарын 9-ний 154 тоот тушаалаар “Чандмань-Эрдэнэ” нэртэй байгуулагдсан. Үүсгэн байгуулагч нь дэд профессор Л.Мөнхбат, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Жанцан нар юм.

2011 онд АНУ-ын Олон Улсын Магадлан Итгэмжлэгдсэн байгууллагын гишүүн сургууль болсон ба БСШУ-ы Сайдын 560-р тушаалаар 2016 он хүртэл аттестатчилагдсан байна. Мөн ондоо Монголын Үндэсний Их Сургууль нэртэй болсон. Тус сургууль нь 6 салбар сургууль, 15 тэнхим, 5000 гаруй оюутан, 200

гаруй эрдэмтэн багш нартай, 56 мэргэжлийн чиглэлээр, бакалавр, магистрын сургалт явуулж байна.

1999 онд тус сургуулийн харьяа Хууль зүйн удирдлагын сургууль байгуулагдаж 2001 онд эрх зүйч мэргэжлээр анхны төгсөлтөө хийсэн байна.

Тус сургууль нь эрүүгийн эрх зүйн тэнхим, төр, захиргааны эрх зүйн тэнхим, иргэний эрх зүйн тэнхимүүдтэй. Захирал, 7 ахлах багш, 5 багштай 620 оюутантай сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Мөн 75 магистрант сурч байна. Сургуульд хичээлийн анги танхимаас гадна шүүх хуралдааны танхим, клиник сургалтын төв, бие хамгаалах урлагийн клуб, хууль тогтоомжийн сан ажилладаг.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Хууль зүйн удирдлагын сургууль нь эрх зүйн өдөр, эчнээ, оройн ангид элсэлт авдаг. Хууль зүйн магистрын сургалт явуулдаг ба Иргэний аюулгүй байдал, бие хамгаалал мэргэжлээр бакалаврын сургалт явуулдаг.

#### **“Хүний эрх, эрх чөлөө” хичээл**

Анги: Бакалаврын 2-р дамжаа  
Судлах хэлбэр: Заавал судлах хичээл  
Цаг: Лекц 24 цаг, семинар 16 цаг  
Багц цаг: 2  
Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2013

**Бусад сургалт, үйл ажиллагаа:** Иргэний эрх зүйн тэнхим нь Хууль зүйн удирдлагын сургуулийн нээлттэй 7 хоногийн хүрээнд 2012 оны 11 дүгээр сарын 29-нд “Үндсэн хууль ба хүний эрх” сэдэвт олимпиадыг ерөнхий боловсролын сургуулийн 11-р ангийн сурагчдын дунд 2 үе шаттай зохион байгуулсан байна. Тус олимпиадад нийслэлийн 10 гаруй сургуулийн 105 сурагч оролцжээ.

#### **2.1.4. Орхон их сургуулийн Хууль зүйн сургууль**

**Сургуулийн товч танилцуулга:** Тус сургууль нь 1992 онд байгуулагдсан хувийн өмчийн анхны сургуулиудын нэг юм. БШУЯ-ны аттестатчлалаар 2 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн.

Сургалтын орчны хувьд хичээлийн 4 байр, 200 оюутны багтаамжтай дотуур байртай. 270 суудалтай номын сан, судалгаа мэдээллийн төв, Компьютер интернэт, гадаад хэлний лингафон, сэтгэл судлал, нягтлан бодох бүртгэл, нарийн бичиг, аялал жуулчлал, хууль зүйн клиник сургалтын төв, криминалистикийн зэрэг төрөлжсөн лабораториудтай. Спорт заал, Оюутны эрүүл мэндийн төв (1 их эмч, сувилагчтай) үйл ажиллагаагаа явуулдаг.

Бүтэцдээ Хүмүүнлэгийн ухааны сургууль, Хууль зүйн сургууль, Эдийн засаг бизнесийн удирдлагын сургуулиудтай. Гадаад хэл, шинжлэл, Боловсрол судлал, менежмент, Эрх зүй, Нягтлан бодох бүртгэлийн магистрийн 1.5-2

жилийн сургалт явуулдаг. Боловсрол судлал, менежмент, Эрх зүйн докторын 3 жилийн сургалт явуулдаг.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Өдөр, эчнээ ангиар эрх зүйч мэргэжилтэн бэлтгэдэг. Өдрийн анги нь 4 жил, эчнээ анги нь 2.5-3 жилийн сургалт явуулдаг.

#### “Хүний эрх” хичээл

Анги: Бакалаврын 2-р дамжаа  
Судлах хэлбэр: Заавал судлах хичээл  
Цаг: Лекц 16 цаг, семинар 32 цаг  
Багц цаг: 2  
Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2011

### 2.1.5. Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** 1991 онд Гадаад хэлний дээд сургууль нэртэй байгуулагдан англи, герман, хятад, франц, япон хэлний орчуулагч-багш мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа явуулж эхэлсэн. 1992 онд Отгонтэнгэр дээд сургууль болж өөрчлөн байгуулагдсан.

1999 онд магадлан итгэмжлэгдэж Гэгээрлийн сайдын 1999 оны 103 тоот тушаалаар их сургуулийн статустай болсон байна. 2004 онд ахисан түвшинд магадлан итгэмжлэгдсэн бол 2013 онд дээд боловсролын байгууллагын аттестатчлалын шалгуур үзүүлэлтийг хангаж аттестатчлагдсан байна.

Бүтцийн гурван сургуультай. Үүнд: Хууль зүйн сургууль, Эдийн засаг, Бизнесийн удирдлагын сургууль, Хүмүүнлэгийн сургууль зэрэг болно. Их сургууль нь нийт 8 тэнхимтэй ба Хууль зүйн сургууль нь Бизнесийн эрх зүй, Олон улсын эрх зүйн тэнхимүүдтэй. Хичээлийн гурван байр, 2 номын сантай. Нийт номын тоо, фондын баяжилт 47,913. Компьютерийн лаборатори, интерактив сургалтын төв, лингафоны кабинет, телемост зайн сургалтын төв, аудио, видео кабинет, “Оюутан” радио үзель, Хууль зүйн клиник сургалтын төв, Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдтэй.

2013-2014 оны хичээлийн жилд нийт 92 багш, 1807 оюутантай ба үүнээс бакалавр 1725, магистр 64, доктор 18, экстернат, орой, эчнээ суралцагчдын тоо 314 байна. 23 жилийн хугацаанд нийт 5166 эрх зүйч бэлтгэсэн.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** 1994-1995 онд олон улсын эрх зүйн мэргэжлээр, 1995 онд хуулийн зөвлөх-өмгөөлөгчийн орой, эчнээ анги, 1996 оноос аж ахуйн эрх зүйч мэргэжлээр бакалаврын сургалт явуулж эхэлжээ. 2000 оноос хууль зүйн магистрын сургалт явуулж эхэлсэн байна.

Өдгөө Хууль зүйн сургууль нь хоёр мэргэжлээр эрх зүйн боловсрол олгож байна. Үүнд: Аж ахуйн эрх зүй, Олон улсын эрх зүй. Мөн хууль зүйн магистр болон докторын сургалт явуулж байна. Бакалаврын дээрх хоёр мэргэжлийн сургалт нь дараах төлөвлөлтөөр явагддаг.

Ерөнхий суурь боловсрол олгох хичээл	31
Мэргэжлийн суурь хичээл:	57
Мэргэшүүлэх хичээл:	21
Мэргэших дадлага	5
Клиник дадлага	12
Нийт багц цаг	126

### “Хүний эрх” хичээл<sup>30</sup>

Анги: Олон улсын эрх зүйн бакалаврын 3-р дамжаа  
 Судлах хэлбэр: Сонгон судлах мэргэшүүлэх хичээл  
 Цаг: Лекц 24 цаг, семинар 16 цаг  
 Багц цаг: 2  
 Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2011

Анги: Аж ахуйн эрх зүйн бакалаврын өдөр, орой, эчнээн 3-р анги  
 Судлах хэлбэр: Сонгон судлах мэргэшүүлэх хичээл  
 Цаг: Лекц 24 цаг, семинар 16 цаг  
 Багц цаг: 2  
 Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2011

Тухайн мэргэжлийн нэг анги дүүргэлт 60 хүнтэй ба сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан 3-4 хичээлийг сонгол судлах хичээлд 15-20 оюутан байхаар зохицуулдаг тул оюутны тоон мэдээллийг сүүлийн 5 жилээр авч үзвэл Аж ахуй эрх зүй, олон улсын эрх зүйн мэргэжлээр жилд дунджаар 30-40 оюутан буюу нийт 150-200 оюутан “Хүний эрх” хичээлийг сонгон хэлбэрээр, заавал судлах хичээлийн хэлбэрээр нийт 190 гаруй оюутан судалж байна.

**Бусад хичээл, үйл ажиллагаа:** Мөн Клиник дадлага-2 хичээлээр “Хүний эрхийг хамгаалах механизм” хичээлийг 16/64 цаг буюу 3 багц цаг судлахаар тусгасан байна. Аж ахуйн эрхзүй мэргэжлийн сургалтын төлөвлөгөөнд “Хүний эрхийг хамгаалах механизм” хичээлийг 16/64 цаг буюу 3 багц цаг, орой, эчнээ ангид заавал судлах мэргэжлийн суурь хичээл болгон 2 багц цагаар оруулсан байна.

#### 2.1.6. Түшээ дээд сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** Тус сургууль нь БСШУ-ны сайдын 1996 оны 8 дугаар сарын 26-ны 06 дугаар тушаалаар Түшээ дээд сургууль гэсэн нэртэй байгуулагдсан. Тусгай зөвшөөрлийн хавсралтад бичигдсэн дээд

<sup>30</sup>Тус сургуулийн 2008 оны хуучин төлөвлөгөөнд Олон улсын эрх зүйн мэргэжлийн суурь хичээлд “Хүний эрх” хичээлийг оруулж 2 багц цаг буюу 16/32 нийт 48 цагийн багтаамжтай 3 дугаар ангид заавал судлах хичээл болгон орж байжээ. Мөн мэргэшүүлэх хичээлийн хүрээнд “Хүний эрх-2” хичээлийг оруулж 2 багц цаг буюу 8/12 нийт 30 цагийн багтаамжтай 4 дүгээр ангид сонгон судлах хичээлээр тусгасан байв. Клиник дадлагын хичээлийн хүрээнд “Хүний эрхийг хамгаалах механизм” хичээлийг оруулж 3 багц цаг буюу 0/96 цагийн багтаамжтай 3 дугаар ангид сонгон судлах хичээл болгон тусгаж дээрх гурван чиглэлээр хүний эрхийн хичээлийг зааж байжээ. Аж ахуйн эрх зүйн мэргэжлийн ангид “Хүний эрх” хичээлийг мэргэжлийн суурь хичээл болгон 2 багц цаг буюу 16/32 нийт 48 цагийн багтаамжтай 3 дугаар ангид заавал судлах хичээл, “Хүний эрхийг хамгаалах механизм” хичээлийг 3 багц цаг буюу 0/96 цагийн багтаамжтай 3 дугаар ангид сонгон судлах хичээл болгон дээрх 3 чиглэлээр хүний эрхийн хичээлийг оруулж байжээ.

боловсрол эзэмшүүлэх чиглэлийн дагуу элсэлт авч бакалаврын болон магистрын сургалт явуулж байна.

Эрх зүйч, Нягтлан бодох, Санхүү эдийн засаг нягтлан бодох бүртгэл, Компьютер програм хангамжийн чиглэлээр дээд боловсрол олгох сургалтыг явуулдаг.

2003 онд “Түшээ” клиник сургалтын төвийг байгуулан ажиллаж байгаа бөгөөд нийгмийн эмзэг давхаргын төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлдэг. 2011 онд ахисан түвшинд магадлан итгэмжлэгдэж, мөн ондоо БШУЯ-аас аттестатчилагдсан. 2013 оноос эхлэн Татварын эдийн засаг нягтлан бодох бүртгэлийн эчнээ ангиудыг шинээр нээжээ. Нийт 28 багш, 364 оюутантай.

Тус сургуулийн хувьд 2009-2015 оны мастер төлөвлөгөө хэрэгжүүлж байгаа бөгөөд уг төлөвлөгөөнд тулгуурлан удирдах зөвлөл, эрдмийн зөвлөл, захиргааны зөвлөл, тэнхим тус бүр жилийн ажлын нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж байна. Мастер төлөвлөгөөний сургалтын үйл ажиллагааг дээшлүүлэх чиглэлд сонгон судлах боломжийг нэмэгдүүлэх замаар бэлтгэн гаргаж буй мэргэжилтний хөрвөх ба мэргэшлийн чадварыг дээшлүүлэх; эрх зүйч, нягтлан бодох бүртгэл, санхүү эдийн засагч мэргэжлийн сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгохын зэрэгцээ танилцах ба үйлдвэрлэлийн дадлагын агуулга арга, хэлбэрийг шинэчлэн сайжруулах; суралцагчдыг судалгаа шинжилгээний ажлын арга барилд сургах, онол практикийг зөв хослуулан хэрэгжүүлдэг мэргэжилтэн болгон бэлтгэх зорилгуудыг тавьсан байна.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Эрх зүйч мэргэшлийн бакалаврын сургалтын төлөвлөгөөний тухайд 0380100 мэргэжлийн индекс бүхий 4 жилийн өдрийн анги хичээллүүлж дээд боловсрол эзэмшүүлж байна. Бакалаврын сургалт нь дараах төлөвлөлтөөр явагддаг.

Ерөнхий суурь боловсрол олгох хичээл	38
Мэргэжлийн суурь хичээл:	54.5
Мэргэшүүлэх хичээл:	24.5
Танилцах дадлага /2 долоо хоног/	2
Үйлдвэрлэлийн дадлага /8 долоо хоног/	4
Курсын ажил	3
Бакалаврын төгсөлтийн ажил	
Нийт багц цаг	<b>126</b>

#### “Хүний эрх” хичээл

Анги: VII улирал  
 Судлах хэлбэр: Заавал судлах мэргэшүүлэх хичээл  
 Цаг: Лекц 16 цаг  
 Багц цаг: 1  
 Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2012

Хүний эрх хичээлийг сүүлийн 5 жилийн хугацаанд судалсан оюутны тоон мэдээлэл:



Хичээлийн жил	Нийт оюутнууд
2009-2010 он	23
2010-2011 он	89
2011-2012 он	52
2012-2013 он	58
2013-2014 он	48
	270

### 2.1.7. Улаанбаатар их сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** 1995 онд Улаанбаатар коллеж нэртэй байгуулагдсан. 2002 онд БСШУ-ны сайдын 2002 оны А/121 дүгээр тушаалаар сургуулийн нэрийг Улаанбаатар дээд сургууль болгон өөрчилсөн. 2011 онд тус сургуулийн Эрх зүйн салбар шинээр нээгдсэн бол 2011 оны 7 дугаар сард Улаанбаатар Их Сургууль болж өргөжсөн байна.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Улаанбаатар их сургууль нь эрх зүй, захиргааны эрх зүйн мэргэжлээр бакалаврын сургалт эрхэлдэг. Мөн эрх зүйн өдөр, эчнээ ангийн магистрын хөтөлбөртэй.

Өдгөө эрх зүйн болон төр-захиргааны 2 тэнхимтэй, эчнээ сургалттайгаар 400 гаруй оюутантай, 6 доктор, профессор бусад багш нар багшилж байна.

#### “Хүний эрх” хичээл<sup>31</sup>

Улаанбаатар их сургуулийн хууль зүйн салбар нь өнгөрсөн 10 жилийн хугацаанд “Өмгөөлөл, хүний эрх” гэсэн хичээл зааж байгаад 2013-2014 оны хичээлийн жилээс “Хүний эрх” бие даасан хичээл судлахаар сургалтын төлөвлөгөөндөө тусгасан байна. Хичээлийн хөтөлбөрт:

- Хүний эрхийн ойлголт, хүний эрх ба төрийн үүрэг
- Хүний эрхийн боловсролын ач холбогдол
- Хүний эрхийг хамгаалах механизм
- Хүний эрхийн олон улсын механизм
- Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөний ойлголт
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль
- Бизнес ба хүний эрх
- Хүрээлэн буй орчны эрх ус агаарын бохирдол асуудлууд
- Хөдөлмөрлөх эрх
- Өмчлөх эрх гэх зэрэг онол, практикт тулгамдсан хүний эрхийн асуудлуудыг сургалтад оюутнуудад зааж байна.

Магистрын хичээлээр “Сайн засаглал, хүний эрх” хичээл ордог талаарх мэдээллийг ирүүлсэн.

<sup>31</sup>ХЭҮК-т хичээлийн хөтөлбөрийг ирүүлээгүй.



### 2.1.8. Үндэсний тагнуулын академи

**Сургуулийн товч танилцуулга:** Тагнуулын ерөнхий газар (ТЕГ)-ын Дээд сургуулийг анх Гэгээрлийн сайдын 1997 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 209 дүгээр тушаалаар Улсын аюулгүй байдлыг хангах газрын Дээд сургууль байгуулах тухай тушаалаар байгуулсан бөгөөд БСШУ-ны сайдын 2009 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн 350 дугаар тушаалаар Үндэсний тагнуулын академи болжээ.

Тус академийн гол онцлог нь ТЕГ болон Зэвсэгт хүчний Жанжин штабын Цэргийн тагнуулын газар, Хил хамгаалах ерөнхий газрын Хилийн тагнуулын газар болон гүйцэтгэх ажил эрхэлдэг бусад байгууллагын захиалгаар мэргэжлийн боловсон хүчнийг нь бэлтгэх, тагнуулын ажилтнуудыг давтан бэлтгэх, мэдлэг, чадварыг дээшлүүлэх, тагнуул судлал, үндэсний аюулгүй байдлын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил явуулах чиг үүрэг бүхий гадаадын зарим орны тусгай албадын сургуулиудын нийтлэг жишгийн дагуу байгуулагдсан Монгол Улсын тусгай албаны, дээд боловсролын байгууллага юм.

2013-2014 оны хичээлийн жилд нийт 37 багш ажилтан ажиллаж, 4 болон 2 жилийн бакалавр, магистрын сургалтад нийт 130 гаруй оюутан суралцаж байна. Мөн жилдээ 1-2 удаа Гүйцэтгэх ажлын 45 хоногийн анхан болон 14 хоногийн давтан сургалт явуулж ирсэн.

Үндэсний тагнуулын академи нь 2012 онд Боловсрол, шинжлэх ухааны яамны аттестатчлалын шалгалтад орж 2017 он хүртэл сургалт явуулах эрхээ баталгаажуулсан ба 2010 онд Мэргэжлийн хяналтын байгууллагаас хийсэн эрсдлийн үнэлгээгээр “хамгийн бага эрсдэлтэй” гэсэн үнэлэлт авсан байна.

Тус академи нь 990м<sup>2</sup> талбай бүхий 3 давхар барилга байгууламжтай бөгөөд бие бүрэлдэхүүний ажиллах, суралцах нөхцлийг бүрдүүлсэн хурлын танхим, амралтын өрөө, гүйцэтгэх ажлын танхим, олон улсын харилцааны танхим, гадаад хэлний 2 танхим бүхий сургалт явуулдаг, 12 анги танхим, лабораторитайгаас 7 нь сургалтын техник хэрэгслээр тоноглогдсон байна.

Номын сан нь нийт 54 уншигчийн суудал бүхий 2 танхимтай, танхим бүр интернетийн холболт бүхий уншигчдад зориулсан компьютертай, принтер, хувилан олшруулагч, сканнер гэх мэт техник хэрэгсэл, каталогийн шүүгээ, сэтгүүлийн болон үзэсгэлэнгийн тавиур гэх зэрэг хэрэгсэлтэй ба 1000 гаруй номыг цахим хэлбэрт оруулсан байна.

Тусгай хичээлүүдийн нууц сурах бичиг, гарын авлагыг багш, ажилтнууд Академи байгуулагдах үеэс өөрсдөө бэлтгэн боловсруулж эхэлсэн.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Тус академи 1997-2008 онд ТЕГ болон бусад байгууллагын захиалгаар Ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчдөөс сонгон элсүүлж, 5 жилийн хугацаагаар бакалаврын сургалт явуулан гадаад хэлний мэдлэгтэй, эрх зүйч мэдлэгтэй тагнуулын ажилтан бэлтгэхийн зэрэгцээ, эрх зүйн эчнээ ангидаа ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчдөөс элсүүлэн 5 жилийн хугацаагаар эрх зүйн бакалавр, энгийн дээд сургууль төгсөгчдөөс элсүүлэн 3.5 жилийн хугацаагаар эрх зүйн

бакалаврын сургалт явуулж эрх зүйч мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж байв.

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Үндэсний тагнуулын академийн сургалтын хэлбэр, хөтөлбөрт өөрчлөлт оруулж, гүйцэтгэх ажил, гадаад хэл, мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшүүлэх замаар тагнуулын албыг мэргэжлийн чадварлаг боловсон хүчнээр бэхжүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд эрх зүйч мэргэжлээр бэлтгэдэг байсныг 2008 онд өөрчлөн “Аюулгүй байдлын ажилтан” мэргэжлээр бакалаврын сургалт явуулж эхэлсэн байна.

Өнгөрсөн хугацаанд Аюулгүй байдлын магистрын сургалтыг явуулж 20 гаруй магистр төгссөн бол байгуулагдсан цагаасаа өнөөдрийг хүртэл 1800 гаруй эрх зүйч болон гүйцэтгэх ажилтан бэлтгэн гаргажээ.

### “Хүний эрх” хичээл

Анги: Бакалаврын 3-р дамжааны 1-р улирал, 2 жилийн бакалаврын 1-р дамжааны 1-р улирал

Судлах хэлбэр: Заавал судлах хичээл

Цаг: Лекц 16 цаг, семинар 16 цаг

Багц цаг: 1.5

Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2012

**Бусад хичээл, үйл ажиллагаа:** Хичээлээс гадуур явуулж буй боловсролын хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааны хувьд тус академи нь жил бүр олон улсын хүний эрхийн өдрөөр Хүний эрхийн сэдэвт эрдэм шинжилгээний илтгэл, өгүүлэл, эссе, танин мэдэхүйн асуулт хариултын АХА, Центавр тэмцээнүүдийг их дээд сургуулийн болон Үндэсний тагнуулын академийн сонсогч, оюутны дунд зохион байгуулж хэвшсэн.

ХЭҮК-той хамтран 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдөр Үндэсний тагнуулын академийн төгсөх ангийн сонсогчдод “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд хүний эрхийг хангах нь” сэдвээр сургалт, 2012 оны 10 дугаар сарын 24-ний өдөр ТЕГ-ын албан хаагч, ажилтнуудад зориулсан сургалтыг зохион байгуулсан.

### 2.1.9. Хууль сахиулахын их сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** Тус сургууль алсын хараагаа тодорхойлохдоо: “Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль сахиулах ажлын шинжлэх ухаан, боловсрол, үйлчилгээний нэгдлийг хангахуйц инновацийн үр ашигтай тогтолцоог хөгжүүлэх, судалгааны тодорхой чиглэлүүдэд тэргүүлэх байр суурьтай, зөвлөх эрхтэй, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн шинжлэх ухааны хамт олон болон төлөвших замаар ард түмнийхээ энх амгалан байдлыг сахиулах, бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулагч мэдлэг, оюуны төв байхад чиглэнэ.” гэжээ.

Сургуулийн үндэс суурь 1934 оны 9 дүгээр сард анх Дотоод явдлын

яамны Төв сургууль байгуулагдсан үеэс эхтэй ба 1944 онд Дотоод явдлын яамны Хязгаарын ба дотоодын цэргийн нэгдсэн сургууль, 1974 онд НАХЯ-ны Цэргийн тусгай дунд сургууль, 1982 онд НАХЯ-ны Цэргийн дээд сургууль, 1990 онд Цагдаагийн дээд сургууль, 1994 онд Цэргийн их сургуулийн Хилийн факультет буюу Хилийн албаны сургууль, 1996 онд ЦИС-ийн Хилийн цэргийн дээд сургууль, 1999 онд БХИС-ийн Хилийн цэргийн сургууль, 1999 онд Цагдаагийн академи, 1999 онд Хилийн цэргийн дээд сургууль, 2011 онд Засгийн газрын 229 дүгээр тогтоолоор Дотоод хэргийн их сургууль, 2012 онд Засгийн газрын 87 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургууль болон бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийгджээ.

Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Хууль сахиулахын их сургуулийн сургалтын хөтөлбөр, агуулга, чанарыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, сургалтын орчинг сайжруулах, эрдэм шинжилгээ-судалгааны ажлыг хөгжүүлэх зорилгоор ХЗЯ-ны харьяа хууль зүйн салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох эрдэм шинжилгээ судалгааны ажлыг сайжруулах зорилгоор агентлагийн статустай Хууль сахиулахын их сургуулийг өөрчлөн байгуулсан байна.

Тус их сургууль нь бүтэцдээ хууль сахиулах албадын удирдах бүрэлдэхүүнийг сургах, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх үндсэн чиг үүрэг бүхий Удирдлагын сургуулиас гадна Цагдаагийн сургууль, Хилийн сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Онцгой байдлын сургууль, Ерөнхий эрдмийн сургууль<sup>32</sup>, Ахлагчийн сургуультай.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Тус сургууль нь бакалаврын зэрэг олгох дараах сургалтуудыг зохион байгуулж байна. Үүнд:

- Цагдаагийн ажил - Эрх зүй
- Цагдаагийн ажил - Эрх зүй (Замын хөдөлгөөний аюулгүй байдал)
- Цагдаагийн ажил - Эрх зүй (Мэдээллийн аюулгүй байдал)
- Цагдаагийн ажил - Эрх зүй (Эдийн засгийн аюулгүй байдал)
- Цагдаагийн ажил-Эрх зүй (Эрүүгийн эрэн сурвалжлах алба)
- Цагдаагийн ажил-Эрх зүй (Мөрдөх алба)
- Цагдаагийн ажил-Эрх зүй (Нийгмийн хэв журам хамгаалах алба)
- Цагдаагийн ажил-Криминалистикийн техник зүй
- Цагдаагийн ажил-Олон улсын эрх зүй
- Цагдаагийн ажил-Сэтгэл судлал
- Олон улсын эрх зүй
- Дотоодын цэргийн ажил-Эрх зүй
- Криминалистикийн шинжилгээ-Эрх зүй
- Онцгой байдлын ажил-Эрх зүй
- Хилийн алба
- Хилийн алба-Олон улсын эрх зүй
- Шалган нэвтрүүлэх алба

<sup>32</sup>Ерөнхий эрдмийн сургууль нь "Сургуулийн бүтэц орон тоог тогтоох тухай" 2011 оны 140-р тогтоолоор "Ерөнхий эрдмийн төв" нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн бөгөөд Хууль зүйн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн "Хууль сахиулахын их сургуулийн бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" Б/20 тоот тушаалаар "Ерөнхий эрдмийн сургууль" нэртэйгээр бие даасан сургууль болон өргөжин зохион байгуулагдсан.

Шалган нэвтрүүлэх алба - Олон улсын эрх зүй  
Хилийн аюулгүй байдлын алба–Эрхзүй  
Арталын алба  
Цэргийн сэтгэл судлал  
Хилийн инженер техникийн алба  
Цэргийн эрх зүй  
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажил-Эрх зүй  
Шүүхийн шийдвэр судлал

### “Хүний эрх” хичээл

Анги: 2-р дамжааны хаврын улирал  
Судлах хэлбэр: Заавал судлах хичээл  
Цаг: 56 цаг, үүнээс Лекц 16 цаг, семинар 16 цаг, дасгал 16 цаг, БУБД 8 цаг.  
Багц цаг: 2  
Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2010

Тус их сургууль нь “Хүний эрх ба цагдаагийн ажил”, “Хүний эрх ба Онцгой байдлын ажил”, “Хүний эрх ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажил”, “Хүний эрх ба Гадаадын харъяатын эрх зүйн байдал” зэрэг хичээлүүдийг 1-4 дүгээр дамжаанд 2 кредит цагийн багтаамжтайгаар дээд боловсролын суурь хичээл болон мэргэшүүлэхийн хичээлийн агуулгад оруулан зааж байна.

Хичээлүүдийн цаг, сэдвийн төлөвлөгөөг үзэхэд “Хүний эрх” хичээл жишиг хөтөлбөрийн дагуу онолын ойлголтыг голчлон заахаар төлөвлөсөн байна. Харин “Хүний эрх ба цагдаагийн ажил”, “Хүний эрх ба онцгой байдлын ажил”, “Хүний эрх ба шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажил”, “Хүний эрх ба гадаадын харъяатын эрх зүйн байдал” хичээлийн цагийн 1/3 цагт хүний эрхийн онолын ойлголтыг, 1/3 цагт процессын ажиллагааны явцад хүний эрхийг хангах асуудал, 1/3 цагт тухайн алба хаагчийн өөрийнх нь эрх зүйн байдлын асуудлыг хамруулсан төлөвлөгөөний дагуу хичээл сургалт явагдаж байна.

Харин ахлагчийн сургууль буюу бага бүрэлдэхүүн (аврагч, харуул, хамгаалалтын албаны ажилтан, цагдаа г.м) бэлтгэдэг сургалтад дээрх хичээлүүд 1 багц цагийн багтаамжтай орж байна.

Сургалтын төлөвлөгөөнд хүний эрхийн хичээлүүд нь заавал судлах хичээлийн бүрэлдэхүүнд орсон байна. Хүний эрхийн хичээлийг судалсан сонсогчдын тоог сүүлийн 5 жилээр жагсаавал:

Хичээлийн жил	Нийт сонсогчид
2009-2010 он	350
2010-2011 он	355
2011-2012 он	298
2012-2013 он	350
2013-2014 он	428

### 2.1.10. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Билэг дээд сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** 2000 оны 04-р сарын 21-ний өдөр анх байгуулагдаж мөн оны 07-р сарын 17-ны өдөр сургалт эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ авсан. 2004 онд анхны төгсөлтөө хийжээ. 2005 онд магадлан итгэмжлэгдсэн дээд боловсролын байгууллага болсон ба 2006 онд эрх зүйн магистрын өдрийн ангийг нээсэн байна.

БСШУ-ын Сайдын 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн №287 тоот тушаалаар Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа сургууль болсон. БСШУ-ын Сайдын 2011 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн №409 тоот тушаалаар Хэл судлаач дээд сургуультай нэгдэж нийт 11 мэргэжлийн чиглэл, мэргэжил дээшлүүлэх 2 сургалттай болж сургалтын хамрах хүрээ нь өргөжсөн.

2012 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр 5 жилийн хугацаатай аттестатчилагдан №19 тоот гэрчилгээ авчээ. Сургалтын төлөвлөгөөгөө 2000, 2005, 2010 онуудад тус тус шинэчлэн боловсруулж батлуулсан байна.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Эрх зүйн өдөр, их, дээдийн оройн анги, олон улсын эрх зүйн өдрийн анги хичээллүүлдэг.

Эрх зүйч мэргэжлийн сургалтаас гадна эрх зүйн магистрын сургалт нь тус сургуулийн эрдмийн зөвлөлийн 2011 онд шинэчлэн баталсан магистрын сургалтын журмын дагуу төрийн боловсролын бодлого, олон улсын нийтлэг жишиг, шинжлэх ухаан, технологийн дэвшилд үндэслэн хууль зүйн ухааны салбараар суралцагсдад сургалт, эрдэм шинжилгээ, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудад мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгааны ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээн хөгжүүлэхэд хэрэгцээт мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгдэж байна.

#### “Хүний эрх” хичээл

Анги: Эрх зүйн бакалаврын 2, 3-р дамжаа  
Судлах хэлбэр: Сонгон судлах хичээл  
Цаг: Лекц 15 цаг, семинар 30 цаг  
Багц цаг: 2  
Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2013

Эрх зүйч мэргэжилтэн бэлтгэдэг сургуулиудын төгсөх ангид 2 багц цаг (48) үзэхээр боловсруулсан бөгөөд хүний эрхийн талаарх онолын болон практик мэдлэгийн зохистой харьцааг тогтоож, хүний эрхийг хангах, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх арга замуудыг хэрэглэх, асуудалд хүний эрхийн мэдрэмжтэй хандах чадварыг нь хөгжүүлэх агуулга, арга зүйг багтаасан.

- Хүний эрхийн болон түүнийг хангах, хамгаалах үндэсний болон олон улсын механизмын талаар мэдлэгтэй болох
- Хүний эрхийн хөгжлийн өнөөгийн чиг хандлагыг танин мэдэх
- Хүний эрхийн зөрчлийг тогтоож, түүнийг шийдвэрлэх, таслан зогсооход олон улсын болон үндэсний механизмыг бүрэн дүүрэн ашиглаж сурах

- Хүний эрхийг баталгаажуулсан олон улсын гэрээ конвенц болон үндэсний хууль тогтоомжийг харьцуулан судлах, тэдгээрт дүн шинжилгээ хийх
- Асуудалд тал бүрээс нь шүүмжлэлтэй ханддаг, бусдыг сонсож, бусадтай хамтран ажилладаг, энэ үндсэн дээр шийдвэр гаргадаг үйл явцад суралцах
- Хуулийн салбарт ажиллах явцдаа асуудалд хүний эрхийн өндөр мэдрэмжтэй ханддаг хандлагад суралцах

### 2.1.11. Шихихутуг хууль зүйн дээд сургууль

**Сургуулийн товч танилцуулга:** Шихихутуг хууль зүйн дээд сургууль 1991 онд байгуулагдсан хувийн өмчийн анхны дээд сургуулиудын нэг юм. 2001, 2006 онд Дээд Боловсролын Магадлан Итгэмжлэх Үндэсний Зөвлөлийн шийдвэрээр Дээд боловсролын байгууллагын анхан шатны болон ахисан түвшний магадлан итгэмжлэлийг тус тус амжилттай хийлгэж, 2011 онд Монгол Улсад хуулийн сургуулиудаас анх удаа эрх зүйн бакалаврын сургалтын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн байна.

Багшлах бүрэлдэхүүний 60 гаруй хувь нь эрдмийн зэрэг цолтой байна. Иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө үнэ төлбөргүй үзүүлэх, тэдний эрх ашгийг нь хамгаалах, оюутнуудад иргэдтэй харилцах, бичиг баримт боловсруулах, мэргэжлийн ур чадвар эзэмшин дадлага олгох клиник сургалтын төв, багш, судлаачид, суралцагсад болон төр, олон нийт, бизнесийн байгууллагын хууль, эрх зүйч мэргэжилтэй судлаачдад судалгаа, шинжилгээний ажлын онол, арга зүйн тусламж үзүүлэх “Шихихутуг” сургалт, судалгааны төв, оюутны илтгэх урлаг, мэтгэлцээний “ГЭРЭГЭ”, шүүхийн мэтгэлцээний “1XP” клуб ажилладаг.

2006 оноос иргэдийн эрх зүйн боловсролд зориулж Монголын үндэсний олон нийтийн радиотой хамтран “Шихихутугийн цаг” нэвтрүүлгийг тогтмол явуулж, “Шихихутуг” сэтгүүлийг эрхлэн гаргаж байна. 20000 гаруй мэргэжлийн болон бусад шинжлэх ухааны ном, сурах бичиг бүхий электрон номын сантай.

**Эрх зүйч мэргэжлийн сургалт:** Шихихутуг хууль зүйн дээд сургууль нь эрх зүй болон бизнесийн эрх зүйн чиглэлээр өдрийн ангид 4 жил, эчнээ ангид 3 жил, магистрантурт 1,5 жилийн хугацаатай сургалт явуулж эрх зүйч, бизнесийн эрх зүйч мэргэжлээр бакалаврын, хууль зүйн магистрын зэрэгтэй эрх зүйчдийг бэлтгэж байна.

#### “Хүний эрх” хичээл<sup>33</sup>

Судлах хэлбэр: Заавал судлах хичээл  
Цаг: Лекц 24 цаг, семинар 16 цаг  
Багц цаг: 2  
Хичээлийн хөтөлбөр баталсан огноо: 2011

Хичээлийг сонгон судалсан оюутны тоон мэдээлэл сүүлийн 5 жилээр:

Хичээлийн жил	Эрх зүйн анги	Бизнесийн эрх зүйн анги	Нийт оюутны тоо
---------------	---------------	-------------------------	-----------------

<sup>33</sup>ХЭҮК-т хичээлийн хөтөлбөрийг ирүүлээгүй.




2009-2010 он	71	18	89
2010-2011 он	59	27	86
2011-2012 он	78	35	113
2012-2013 он	87	35	112
2013-2014 он	64	30	94

## 2.2. Сэдвийн дүгнэлт

Хүний эрх нь Монгол Улсад эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөний нэг хэсэг болсон байна. Гэхдээ эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудад бакалаврын түвшинд “Хүний эрх” хичээлийг зааж буй байдал харилцан адилгүй байна.

**Судлах хэлбэр:** Тухайлбал, судалгаанд хамрагдсан 11 сургуулийн 6 нь уг хичээлийг заавал судлах хичээл болгон үзэж байгаа бол Их засаг олон улсын их сургууль, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургууль, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билэг дээд сургууль болон Улаанбаатар их сургуульд уг хичээлийг сонгон судлахаар сургалтын төлөвлөгөөндөө тусгажээ.



**Заавал судлах**

- Орхон их сургууль
- Түшээ дээд сургууль
- Үндэсний тагнуулын Академи
- Хууль сахиулахын их сургууль
- Шихихутаг дээд сургууль
- МУИС-ийн Хууль зүйн удирдлагын сургууль

**Сонгон судлах**

- МУИС-ийн Хууль зүйн сургууль
- Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургууль
- Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Билэг дээд сургууль
- Их засаг олон улсын их сургууль
- Улаанбаатар их сургууль


“Хүний эрх” хичээл эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд харилцан адилгүй байдлаар тусгагдсан нь дараах урьдач шалтгаантай байна.

Нэгдүгээрт, 2001 онд Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 91/91 тоот тушаалаар “Эрх зүйн бакалаврын зэрэг олгох сургалтын агуулгын үндэсний стандартыг туршилтын журмаар баталж, заавал үзэх мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтаас хүний эрх хичээлийг хассан нь зарим сургуулиуд уг хичээлийг сургалтын төлөвлөгөөнийхөө заавал судлах хичээлийн жагсаалтаас хасахад хүргэсэн байна.


Хоёрдугаарт, дээрх стандарт батлагдснаар заавал судлах ерөнхий суурь хичээл, түүний багц цагийг тогтоохдоо 3-8 багц цагаар судлах 8 хичээлийг заавал судлахаар тусгаж эдгээр нь 36-аас доошгүй багц цагтай байхаар зохицуулсан нь сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь хичээл, түүний багц цаг нэмэгдэхэд хүргэжээ.

Улмаар дээрх стандартад мэргэжлийн суурь болгон заавал судлах 21 хичээл буюу 2-4 багц цаг, нийт 49 багц цагийн, мэргэших дадлагын 10 багц цагаас доошгүй хичээлийг заавал судлах хичээл болгон тусгахаар оруулсан зэргээс шалтгаалан мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээл, түүний багц цагт өөрчлөлт орж багасгах, агуулгад нь багтааж нэгтгэн оруулах зохицуулалт хийсэн байна. Үүний улмаас “Хүний эрх” хичээлийн багц цаг багассан байна.


**Багц цагийн хуваарилалт:** Их, дээд сургуулиудад уг хичээлд хуваарилсан багц цагийг авч үзвэл дараах байдалтай байна.



Хүснэгтээс үзвэл Түшээ дээд сургууль “Хүний эрх” хичээлийг заавал судлах хичээлийн жагсаалтад оруулсан ба 1 багц цагийн сургалт явуулж байна. Мөн Үндэсний тагнуулын академи заавал судлах хичээлийн жагсаалтад оруулж 1.5 багц цагийн сургалт явуулж байна. Бусад 9 сургуулийн хувьд 2 багц цагийн сургалтыг заавал болон сонгон судлах хичээлийн ангилалд оруулан сургалт явуулж байна.




**Уг хичээлийг судалсан оюутнуудын тоо:** Их, дээд сургуулиудаас ирүүлсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл тухайн хичээлийг судалсан оюутнуудын тоо мөн адил харилцан адилгүй байна. Тухайлбал сүүлийн 5 жилийн статистик мэдээллийг гаргаж үзэхэд Их засаг их сургууль болон Хууль сахиулахын их сургууль уг хичээлийг судалсан оюутнуудын тоогоор бусдаасаа илүү байна. МУИС-ийн Хууль зүйн сургуулиас ирүүлсэн мэдээлэлд дурдсанаар “Хүний эрх” хичээлийг сүүлийн 5 жилийн хугацаанд оюутнууд сонгон судлаагүй байна.



Судалгаанд хамрагдсан 11 сургуулийн “Хүний эрх” хичээлийн хөтөлбөрт хүний эрхийн онолын мэдлэг, үндсэн ойлголт, олон улсын болон

үндэсний эрх зүйн баримт бичгийн талаарх дэд сэдвүүд орсон хэдий ч олон улс болон Монгол Улсын бодит амьдрал дээр тулгарч буй хүний эрхийн асуудлуудыг тодорхойлж оруулах нь чухал юм. Дээрх сургуулиудын “Хүний эрх” хичээлийн хөтөлбөр нь бусад сургалтын хөтөлбөрүүдтэй залгамж холбоотой байх бөгөөд уг хичээлийн өмнө заавал “Үндсэн хуулийн эрх зүй” хичээлийг судалсан байхаар тусгажээ. Дээрх 11 сургуулиас 9 сургуульд<sup>34</sup> нь “Хүний эрх” хичээлийг 2-р дамжаанаас эхлэн зааж байна.



Хүний эрхийн хичээлийг цаашид дэлгэрүүлэн судлах боломж оюутан бүрт нээлттэй байхын зэрэгцээ бие даалт, ангийн ажил болон бакалаврын, магистрын, төгсөлтийн ажлын сэдэв болгон сонгон бичиж байна. Мөн бусад байгууллагуудтай<sup>35</sup> хамтран ажилладаг ба, уг ажилд оюутнуудыг хамруулж байна.

“Хүний эрх” хичээлийг судалж буй оюутнуудад уг хичээлтэй холбоотой уншиж судлах ном товхимлын сонголт муу байна. Хүний эрх нь онолын түвшинд, практикт ч хурдацтай хувьсан өөрчлөгдөж байдаг, тиймээс 10 жил ба түүнээс өмнөх хугацаанд хэвлэгдсэн эх сурвалж нь суурь, үндсэн ойлголтууд л өгөх боломжтой, харин өнөөгийн хүний эрхийн нөхцөл байдлын талаар төдийлөн оновчтой ойлголт өгөхөд эргэлзээтэй юм.

Иймд цаашид эрх зүйн боловсрол болгож буй их, дээд сургуулиудад “Хүний эрх” хичээл сургалтын төлөвлөгөөнд харилцан адилгүй тусгагдсан байгааг харгалзан үзэж ХЭБДХ-ийн 2 дахь үе шатны үйл ажиллагаанд нийцүүлэн эрх зүйн бакалаврын зэрэг олгох сургалтын агуулгын үндэсний стандартад өөрчлөлт оруулах нь зөв юм.

<sup>34</sup> Шихихутуг их сургууль болон Улаанбаатар их сургуулиуд хэд дүгээр дамжаанаас Хүний эрх хичээлээ заадгийг илгээсэн мэдээлэлд дурдаагүй байсан

<sup>35</sup> НҮБ-ын Хүүхдийн сан, Хүний эрх, хөгжил төв, Эмнести Интернешнл гэх мэт олон улсын, улсын төрийн болон төрийн бус байгууллагууд

## “ХҮНИЙ ЭРХ” ХИЧЭЭЛИЙГ ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

№	Сургууль	Багц цаг	Лекц/ семинарын цаг	Хичээл орж эхэлсэн огноо	Хичээлийн хөтөлбөр баталсан огноо	Сонгон судлаж буй байдал	ХҮНИЙ ЭРХ хичээлд нийт хамрагдсан оюутан /сүүлийн 5 жилээр/	Нэмэлт тайлбар
1	МУИС-ХЗС	2	24л/16с	1999	2012	Сонгон	0	Хүний эрхийн 3 төрлийн хичээл ордог
2	Хууль сахиулах их сургууль	2	16л/16с/16д/ 8БУБД	1997	2010	Заавал	1781 оюутан	2-р дамжаа, 2-р семестр
3	Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургууль	2	15л/30с	2006	2013	Сонгон	342	
4	Үндэсний тагнуулын Академи	1.5	16л/16с	2008	2012	Заавал	130	Бакалаврын 3-р дамжаа, 1 семестр
5	Отгонтэнгэр дээд сургууль	2	24л/16с	2008	2012	Сонгон	370	
6	Шихихутуг их сургууль	2	24л/16с	1992	2011/2003	Заавал	494	
7	Түшээ дээд суургууль	1	16л	2009	2012	Заавал	270	7-р улирал
8	Их засаг их сургууль	1.5	16л/16с	1994	2014	Заавал	ХЗС-ийн 2-р дамжааны бүх оюутнууд	
9	Орхон дээд сургууль	2	16л/32с	1996	2011	Заавал	725	3-р улиралд
10	Улаанбаатар их сургууль	1		2003				
11	МҮИС, Хууль зүйн удирдлагын сургууль	2	24л/16с	2002	2013	Заавал	260	

**“ХҮНИЙ ЭРХ” ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН СЭДВИЙН АГУУЛГЫН ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ**

Сургууль	Сэдэв
1. МУИС-Хууль зүйн сургууль	<ol style="list-style-type: none"> <li>1. Удиртгал хичээл</li> <li>2. Хүний эрхийн онолын үндсэн асуудлууд</li> <li>3. Үндсэн хуулийн эрх зүйн хүний эрхийн баталгаа</li> <li>4. Салбар эрх зүй- хүний эрхийг хамгаалах нь</li> <li>5. ОУ эрх зүйн хүний эрхийн баталгаа</li> <li>6. Хүний эрхийн төлөв байдал</li> <li>7. Хүний эрхийн зөрчил, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа</li> <li>8. Хүний суурь эрхүүд</li> <li>9. Хүний эрх - тодорхой төрлийн эрхүүд</li> </ol>
2. Хууль сахиулах их сургууль	<ol style="list-style-type: none"> <li>1. <i>Лекц:</i> Хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт, мөн чанар</li> <li>2. Хүний эрхийн ойлголт бүрэлдэн тогтсон үе шат, түүхэн хөгжил</li> <li>3. Хүний эрхийн зарчим, тэдгээрийн агуулга, хэрэгжилт</li> <li>4. Хүний эрхийн ангилал, болон зарим хязгаарлалт, үүргийн тухай</li> <li>5. Хүний эрхийн баталгаа, түүний төрөл</li> <li>6. Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм</li> <li>7. Хүний эрхийг хамгаалах ОУ механизм</li> <li>8. Гал түймрийн үед Хүний эрхийг хангах арга ажиллагаа</li> </ol> <p><i>Семинар:</i> 1. Хүний эрхийг судлах хэрэгцээ шаардлага, Хүний эрхийн боловсролын тогтолцоо</p> <ol style="list-style-type: none"> <li>2. МУ дахь Хүний эрхийн үзэл санааны төлөвшил, хөгжил</li> <li>3. Хүний эрхийн зарчмын хэрэгжилт, анхаарах зарим асуудал</li> <li>4. Хувийн эрх, эрх чөлөө, тэдгээрийн хэрэгжилт, анхаарах зарим асуудал</li> <li>5. Иргэний улс төрийн эрхүүд, тэдгээрийн хэрэгжилт, анхаарах асуудал</li> <li>6. Хүний эрхийн төрийн бус байгууллагуудын онцлог, тогтолцоо тэдгээрийн нийгэмд гүйцэтгэх үүрэг</li> <li>7. Хүний эрхийн ОУ-ын гэрээний тогтолцоо</li> <li>8. Гамшгийн бусад эрсдлийн үеийн хүний эрхийг хангах ажиллагаа</li> </ol>





<p>3. Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн харьяа Билиг дээд сургууль</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүний эрх, эрх чөлөө түүний мөн чанар</li> <li>2. Хүний эрхийн үзэл санааны хөгжлийн түүх</li> <li>3. Хүний эрхийн ангилал</li> <li>4. Хүний эрхийн зарчим, үүргийн тухай</li> <li>5. Амьд явах эрх</li> <li>6. Шүүхэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дах хүний эрх, эрх чөлөө</li> <li>7. Эвлэлдэн нэгдэх эрх</li> <li>8. Мөрдөн шалгалт хийх</li> <li>9. Үндэсний хууль тогтоомжийг хүний эрхийн зарчимд нийцүүлэх нь</li> <li>10. Хүний эрхийг хангах, хамгаалах механизм (ОУ)</li> <li>11. Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм (УИХ, Гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд)</li> <li>12. Шүүх эрх мэдлийн байгууллагууд хүний эрхийг хамгаалах, хангах механизм болох нь</li> <li>13. Хүний эрхийн үндэсний байгууллага</li> <li>14. Иргэний нийгмийн байгууллагууд хүний эрхийг хангах механизм болох нь</li> <li>15. Иргэн хүн хүний эрхийг хамгаалах</li> </ol>
<p>4. Үндэсний тагнуулын Академи</p>	<ol style="list-style-type: none"> <li>1. Хүний эрхийн ойлголт, үзэл санааны түүхэн хөгжил</li> <li>2. Хүний эрхийн ангилал</li> <li>3. Хүний халдашгүй эрх</li> <li>4. Захиргааны эрх зүйн актыг Хүний эрхийн зарчимд хийцүүлэх нь</li> <li>5. Хүний эрх ба гүйцэтгэх ажил</li> <li>6. Хүний эрхийг хангаж, хамгаалах үндэсний механизм</li> <li>7. Хүний эрхийг хангаж хамгаалах ОУ механизм</li> </ol>

<p>5. Отгонтэнгэр дээд сургууль</p>	<p><b>ХҮНИЙ ЭРХ- 1:</b> <i>Лекцийн сэдэв:</i> 1. ХҮНИЙ ЭРХ түүний мөн чанар 2. Хүний эрхийн түүхэн хөгжил 3. Хүний эрхийн ангилал, зарчим болон хязгаарлалт, үүргийн тухай 4. Бүлгийн ба хамтын эрх 5. Хүний эрхийг хамгаалах олон улсын механизм 6. Хүний эрхийг хамгаалах үндэсний механизм 7. Үүрэг ба ХҮНИЙ ЭРХ 8. Хүний эрхийн зөрчлийг мөрдөн шалгах нь 9. ИУТЭОУП ба ЭЗНСЭОУП <i>Семинарын сэдэв:</i> 1. Хүний эрх гэж юу вэ? 2. Шүүхээр хянан шийдвэрлэх явцад хүний эрхийг хамгаалах нь 3. Эдийн засаг, нийгэм соёлын эрхүүд, тэдгээрийн хэрэгжилтэнд гарч буй бэрхшээлтэй асуудлууд 4. Жендерийн тухай асуудал 5. Үндэсний хууль тогтоомид дүн шинжилгээ хийх 6. Захиргааны акт ба ХҮНИЙ ЭРХ 7. Хүний эрхийг хамгаалах Үндэсний механизм 8. Хүний эрхийг хамгаалах ОУ механизм</p> <p><b>ХҮНИЙ ЭРХ- 2:</b> <i>Лекцийн сэдэв:</i> 1. ОУ ХҮНИЙ ЭРХ эрх зүйн ойлголт 2. ИУЭТОУП, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 3. Эдийн засаг, нийгэм соёлын эрхийн тухай олон улсын пакт, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 4. Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 5. Эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахыг устгах конвенц, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 6. Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай конвенц, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 8. Арьс үндсээр ялгаварлан гадуурхах бүх үзлийн бүх хэлбэрийг устгах тухай ОУ конвенц, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 9. Бүс нутгийн Хүний эрхийн гол баримт бичгүүд, түүний хэрэгжилтийг хангах ОУ механизм 10. Эрх чөлөө хязгаарлагдсан хүмүүсийг хамгаалах тухай ОУ эрх зүйн стандартын тухай 11. Гэмт хэрэг болон хүний эрхийн зөрчлөөс хохирогсдыг хамгаалах, хохирлыг нь арилгах ОУ эрх зүйн зохицуулалт <i>Семинарын сэдэв:</i> 1. Хүний эрхийн зөрчил, тдгээрийн ангилал, ОУЭЗ-н хэм хэмжээ 2. Иргэний болон улс төрийн эрхийг шүүхээр хамгаалах 3. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг шүүхээр хамгаалах 4. Шүүн таслах ажиллагаанд Хүүхдийн эрхийг хамгаалах 5. Шүүн таслах ажиллагаанд Эмэгтэйчүүдийн эрхийг хамаалах 6. Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэн цээрлүүлэх тухай конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавих олон улсын механизм 7. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтэнд хяналт тавих олон улсын механизм 8. Онц байдлын үед хүний эрхийг хамаалах арга замууд</p>
<p>6. Шихиху туг их сургууль</p>	<p>Мэдээллээ ирүүлээгүй.</p>
<p>7. Түшээ дээд сургууль</p>	<p>1. Хүний эрх, түүний мөн чанар 2. Хүний эрхийн түүхэн хөгжил 3. Хүний эрхийн ангилал 4. Хүний эрхийн зарчим болон хязгаарлалт, үүргийн тухай 5. Тодорхой эрхүүд 6. Хүний эрхийн зөрчил, түүнийг тогтоох зарим аргачлал 7. Үндэсний хууль тогтоомж болон актыг Хүний эрхийн зарчимд нийцүүлэх нь 8. Хүний эрхийг хамгаалах ОУ механизм</p>

8. Их засаг их сургууль	1. ХҮНИЙ ЭРХ судлал, Хүний эрхийн зарчмууд 2. Хүний эрхийн үүсэл хөгжил, хүний эрхийн талаархи онолын үзэл баримтлал 3. Хүний эрхийн ойлголтыг агуулгаар нь авч үзэх 4. Хүний эрхийн талаарх ОУ баримт бичиг 5. ХҮНИЙ ЭРХ, эрх чөлөө үндсэн хуульд тусгагдсан байдал 6. Үндэсний аюулгүй байдал- ХҮНИЙ ЭРХ 7. Хүний эрхийн асуудлыг материаллаг эрх зүйгээр зохицуулах нь 8. Хүний эрхийн асуудлыг процессын эрх зүйгээр зохицуулах нь 9. Хүний эрхийг хамгаалах бүс нутгийн байгууллага, хамтын ажиллагаа
9. Орхон дээд сургууль	<i>Лекцийн сэдэв:</i> 1. Хүний эрх, түүний мөн чанар, түүхэн хөгжил:Хүний эрхийн ойлголт, Хүний эрхийн ойлголт бүрэлдэн тогтсон үе шат, түүхэн хөгжил 2. Хүний эрхийн ангилал, зарчим болон зарим хязгаарлалт, үүргийн тухай: Хүний эрхийг ангилах шалгуур, Хүний эрхийн зарчмууд, Хүний эрхийн хязгаарлалт, Иргэний үүрэг 3 . Хүний эрхийг хамгаалах механизм: ОУ болон Үндэсний 4. Хүний эрхийн зөрчил, түүнийг арилгах зам: Хүний эрхийн зөрчил, түүний онцлог, Хүний эрхийн зөрчлийг шалган илрүүлэх ажиллагаа, Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь <i>Семинарын сэдэв:</i> 1. Хүний эрх гэж юу вэ? Хүний эрх, эрх чөлөөний тухай ойлголт, Хүний эрхийн боловсролын тогтолцоо 2. Тодорхой эрхийн тухай, Амьд явах эрх, Халдашгүй дархан байх эрх, Иргэний улс төрийн эрхүүд, Нийгэм эдийн засаг, соёлын эрхүүд 3. Эрх үүргийн харилцан шүтэлцээ, Үүрэг гэж юу вэ? Үүргийн асуудлыг эрх зүйгээр зохицуулсан нь 4. Хүний эрхийг ханган хамгаалах механизм, Хүний эрхийг хангах Үндэсний байгууллагуудын тогтолцоо, Хүний эрхийг хамгаалах олон улсын байгууллагууд
10. Улаанбаа тар их сургууль	1. Хүний эрхийн ойлголт, хүний эрх ба ба төрийн үүрэг 2. Хүний эрхийн боловсролын ач холбогдол 3. Хүний эрхийг хамгаалах механизм 4. Хүний эрхийн ОУ механизм 5. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөний ойлгол 6. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 7. Бизнес ба хүний эрх 8. Хүрээлэн буй орчны эрх, ус агаарын бохирдол асуудлууд 9. Хөдөлмөрлөх эрх 10. Өмчлөх эрх гэх зэрэг онол, практикт тулгамдсан Хүний эрхийн асуудлууд
11. МУИС, Хууль зүйн удирдлагын сургууль	1. Хүний эрх, түүний мөн чанар 2. Хүний эрхийн түүхэн хөгжил 3. Үндсэн хууль ба хүний эрх 4. Хүний эрхийн ангилал 5. Хүний эрхийн зарчмууд 6. Хүний эрхийн боловсрол 7. Хүний эрхийн хязгаарлалт 8. Тодорхой эрхүүд 9. Хамтын ба бүлгийн эрх 10. Эрүүдэн шүүлтийн тухай ойлголт 11. Хүний эрх ба ОУ эрх зүй 12. Хүний эрхийг хамгаалах ОУ механизм



## ГУРАВ. ЗАРИМ ГАДААДЫН ИХ СУРГУУЛИЙН ХҮНИЙ ЭРХИЙН СУРГАЛТ


Гадаад улс орнуудын хуулийн сургуулиудад хүний эрхийн сургалт ямар агуулгатай байдаг тухайд нэгдсэн хариулт өгөх боломжгүй юм. Учир нь хүний эрхийн хичээлийн агуулга нь тухайн улсын хүний эрхийн хөгжил, улс төрийн орчин, үндэсний болон соёлын онцлог, эрх зүйн тогтолцоо зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байна. Мөн хүний эрхийн тухай ойлголт хуулийн сургалтад бусад эрх зүйн салбартай харьцуулбал өвөрмөц байр суурь эзэлдэгтэй холбоотой байж болох юм. Хүний эрх нь нэг талаар эрх зүйн онол, түгээмэл зарчимд сууж өгсөн эрх зүйн салбар бүрт хамааралтай онолын суурь ойлголт бол нөгөө талаар эргээд хүний эрхийг зөрчсөн тодорхой хэрэг тохиолдолд авч үзэх шаардлагатай прагматик ойлголт гэсэн хоёр талтай гэж дүгнэж болно.

Тэгвэл ийм хоёр талт шинж чанарыг сургалтын хөтөлбөрийн агуулгад хэрхэн тусгах нь тухайн улсын эрх зүйн тогтолцооноос нилээд хамааралтай байх дүр зураг ажиглагдаж байна. Тухайлбал ХБНГУ-ын хуулийн сургалтад хүний эрхийн хичээлийг төрийн эрх зүйн үндсэн гурван багц хичээлийн нэг болгон “Төрийн эрх зүй 2” гэж томъёолсон байдаг. Энэ хичээлийн хүрээнд Үндсэн хуульд тусгасан иргэний болон хүний үндсэн эрхийн тухай зүйл заалтыг онолын хувьд хэрхэн ойлгож тайлбарлах, эрх нь зөрчигдвөл үндэсний болон олон улсын эрх зүйн ямар арга хэрэгсэл, хуульд заасан ямар процессоор хамгаалах боломжтой байдгийг хуулийн бодлого бодох нарийн тогтсон дэс дараалал, зааварчилгааны хүрээнд шалгалт хийж тогтоох арга ажиллагаанд суралцдаг.

Англи Саксоны эрх зүйн тогтолцоонд хамаардаг улсуудын хувьд хүний эрх гэсэн тусдаа лекц семинар байхгүй бөгөөд харин хүний эрх гэсэн томъёололд багтах үндэсний болон дэлхий нийтийн практик жишээнд тулгуурлан олон төрлийн сэдвээр заадаг байна. Ийм хичээлээр хүний эрхийн талаарх олон улсын болон үндэсний хэмжээнд яригдаж байгаа цаг үеийн асуудлыг хүний эрхийн өнцгөөс харж, дүгнэлт өгөхийг зорьдог байна.

Тэгвэл Азийн болон хөгжингүй улсуудын их сургуулиуд дахь хүний эрхийн сургалтыг дээрх хоёр ангиллын аль нэгэнд нь хамааруулж болох хэдий ч хүний эрхийн талаарх уламжлалт ойлголт төдийлөн түгээмэл биш явж ирсэн, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин, улс төрийн нөхцөл байдал, үндэсний болон соёлын онцлог, шашин, ёс заншилд баригдмал, мэдээлэл муу байдаг зэрэг шалтгаанаар хүний эрхийн сургалтад тогтсон аргачлал, агуулга үгүй байх ерөнхий байдал ажиглагдаж байгаа юм.

Судалгааны энэ хэсэгт дээрх ерөнхий дүр зурагт үндэслэн гадаад улс орнуудын хуулийн сургуулиудын хөтөлбөрт хүний эрхийн сургалт хэрхэн туссан байгааг дараах 3 ангиллаар илүү тодорхой гаргахыг зорьсон болно.



Дээрх ангилалд хамааруулан Харвардын хуулийн сургууль, Картины их сургууль, Калкуттагийн их сургууль, Хонгконгийн их сургууль, Бонны их сургуулийн хуулийн факультетуудад бакалавр болон мастерын түвшинд хүний эрхийн сургалт ямар агуулга, арга зүйгээр ордог тухай болон тухайн улсын хувьд хүний эрхийг дээд боловсролын түвшинд заахад ямар бодлого баримталдаг талаар авч үзсэн болно. Түүнчлэн хүний эрхийн сургалтын бакалаврын түвшний агуулгыг АНУ болон Германы их сургуулийн хичээлийн хөтөлбөрөөр, харин бусад сургуулиудын хувьд бакалаврын дараах сургалтын агуулгыг голчлон харуулав.

### 3.1. Англи саксоны эрх зүйн тогтолцооны улсууд: АНУ ба Австралийн жишээнд

2008 онд Штрасбург хотноо Европын зөвлөлтэй хамтран Иргэний хариуцлага ба ардчилал, Дээд Боловсролын Олон Улсын Консерциумын АНУ-ын удирдах зөвлөлөөс зохион байгуулсан форумд “Дээд боловсролын түвшинд хүний эрхийн боловсролыг мэргэшсэн (тухайн эрх зүйн салбарын хүрээнд) болон ерөнхий (бүх төрлийн мэргэжлийн хүрээнд) гэсэн хэлбэрээр олгож байна. Хүний эрхийн боловсролыг чанаржуулах зорилгоор хүний эрхийн зөрчлийг бодит амьдрал дээр олж харан түүнийг хамгаалах арга хэмжээг олж тогтоох гэсэн идэвхитэй оролцооны аргууд хөгжиж байна.”<sup>36</sup> гэж онцлон тэмдэглэсэн байна.

АНУ болон Европын улсуудын хууль зүйн сургуулиудын хүний эрхийн чиглэлээрх лекц, семинар, клиник сургалтын агуулгаас харахад энэхүү идэвхитэй оролцооны арга өргөн хэрэглэгддэг болох нь батлагддаг. Өөрөөр хэлбэл хүний эрхийн сургалтын хөтөлбөрөөр суурь мэдлэгийг олгохоос гадна тухайн цаг үеийн тулгамдсан асуудлуудыг хөндсөн агуулгаас ихэнхдээ бүрдэж байна.

<sup>36</sup> The final report of the Invitational Forum on “Converging Competences: Diversity, Higher Education, and Sustainable Democracy,” organised jointly by the Council of Europe and the US Steering Committee of the International Consortium for Higher Education, Civic Responsibility and Democracy, Strasbourg, 2-3 October 2008. cited in page 156. Human rights education in Ireland. By Irish human rights commission. 2011. ([http://www.ihrc.ie/download/pdf/human\\_rights\\_education\\_in\\_ireland\\_an\\_overview.pdf](http://www.ihrc.ie/download/pdf/human_rights_education_in_ireland_an_overview.pdf)). Сүүлд нэвтэрсэн 2014.04.02

## а) АНУ-ын Харвардын хуулийн сургууль

АНУ-ын Хууль зүйн сургуулиудыг магадлан итгэмжлэх стандарт шаардлага 2013-2014 гэсэн баримт бичгийн стандарт 302-308-д<sup>37</sup> хуулийн сургуулиуд үйл ажиллагаандаа тавих зорилго, сургалтын хөтөлбөрийн агуулга, академик стандарт түвшин, хичээлийн жилийн хуанли, танхимаас гадуур сургалт, зайн сургалт, гадаадын сургуультай сургалтын талаар хамтын ажиллагаа, докторын зэрэг олгох сургалтын нэмэлт хөтөлбөр гэсэн 8 үзүүлэлтээр ямар шаардлага хангах ёстойг зааж өгсөн байна.

Хуулийн сургуулийн сургалтын зорилгыг:

1. Оюутныг Барын холбооны гишүүн болгоход сургаж бэлтгэх, хуульчийн мэргэжлээр идэвхитэй, хариуцлагатай ажиллах чадвар эзэмшүүлэх,

2. Оюутан бүрт сургалтын хөтөлбөрт ижил тэгш хамрагдах, сурч боловсрох ижил тэгш нөхцөл боломж олгох гэж тодорхойлсон байна.

Мөн стандартын 302, (a,b)-д сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг заасан ба ерөнхийд нь дүгнэвэл нэг талаас оюутнуудад академик мэдлэг, мэргэжлийн чадварыг ямар сургалт, ямар арга технологээр эзэмшүүлэх (эрх зүйн анализ, логик гаргалгаа, судалгаа, мэргэжлийн илтгэх ур чадвар гэх мэт), нөгөө талаас оюутан мэргэжлийн дадлага, чадвар олж авахад сургууль ямар бололцоогоор хангах ёстойг нэг бүрчлэн заасан байна. Дадлагажих боломж бололцоогоор хангах гэдэгт:

(1) хуульчийн мэргэжлийн үнэ цэнэ, мэдлэг, хариуцлагын талаар бодит амьдралаас өөрсдөө суралцах боломж нөхцлийг хангах, өөрийн амжилтыг үнэлж, хөгжүүлэхэд нь удирдан чиглүүлэх,

(2) эрх зүйн зөвлөгөө үнэгүй үзүүлэх гэх мэт сайн дурын үйл ажиллагаанд оролцуулах,

(3) семинарыг аль болох бага оюутантай байхаар зохион байгуулах, оюутнуудыг багаар ажиллуулах, судалгааны ажилд чиглүүлж дадлагажуулах нөхцлийг бий болгохыг ойлгоно гэжээ. Барын холбооноос гаргасан дээрх стандартыг хуулийн сургуулиуд сургалтын хөтөлбөртөө заавал тусгах ёстой байдаг байна.

Жишээ болгон Харвардын хуулийн сургуулийн хүний эрхийн сургалтын хөтөлбөрийг авч үзье. Харвардын хуулийн сургуулийн 2013-2014 оны хичээлийн жилийн хөтөлбөрт хүний эрх гэсэн сэдвийн доор хайлт<sup>38</sup> хийхэд нийт 19 төрлийн хичээл орсон байна. Үүнд: Хүний эрхийн өмгөөллийн ур чадвар (ахисан түвшин), Амьтны эрх, Зэвсэгт мөргөлдөөн ба хүний эрхийн хамгаалал, Бизнес ба хүний эрх (дадлагын семинар), Хүүхэд залуучууд ба

<sup>37</sup>ABA Standards and Rules of Procedure for Approval of Law Schools 2013-2014 ([http://www.americanbar.org/content/dam/aba/publications/misc/legal\\_education/Standards/2013\\_2014\\_final\\_aba\\_standards\\_and\\_rules\\_of\\_procedure\\_for\\_approval\\_of\\_law\\_schools\\_body.authcheckdam.pdf](http://www.americanbar.org/content/dam/aba/publications/misc/legal_education/Standards/2013_2014_final_aba_standards_and_rules_of_procedure_for_approval_of_law_schools_body.authcheckdam.pdf)). Сүүлд нэвтэрсэн 2014.03.25.

<sup>38</sup>Harvard law school. Curriculum. (<http://www.law.harvard.edu/academics/curriculum/catalog/index.html?type=Clinic&type=Course&type=Reading+Group&type=Seminar&rows=10&year=2013-2014>). Сүүлд нэвтэрсэн 2014.03.25



хүний эрх, Хүрээлэн буй орчны эрх зүй ба нийтийн бодлого (дадлага), Даяарчлал ба засаглал, Даяарчлалын эрх зүй ба засаглал, Цагаачлал ба дүрвэгсэд (дадлага), Хүний эрхийн өмгөөлөл, Хүний эрхийн тулгамдсан асуудал: хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх (олон улсын ба харьцуулсан эрх зүй судлалд), Цагаачлалын эрх (баримтлах бодлого ба нийгэм дэх өөрчлөлт), Цагаач ба дүрвэгсдийн өмгөөлөл, Олон улсын хүний эрх, Олон улсын хүний эрх (дадлага), Олон улсын эрх зүй (семинар), Эрхээ эдлэх боломж (Ганад туслах төсөл), Эрхээ эдлэх боломж (Ганад туслах төсөл-дадлага), Хүний эрх ба НҮБ-ын үндсэн байгууллагууд, Цагаачлал ба дүрвэгсдийн эрх зүй гэсэн хичээлүүд багтаж байна.

Энд тэмдэглэхэд дээрх хичээлийн хөтөлбөр нь зөвхөн 2013-2014 оны хичээлийн жилд хүчинтэй бөгөөд тухайн жилд ямар асуудал анхаарал татаж байсан, ямар профессор, ямар чиглэлээр уригдан лекц унших зэргээс шалтгаалаад жил бүр хүний эрхийн сэдвээр орох хичээлийн хөтөлбөрийн агуулга өөр байна. Сонгон суралцах боломжтой тул жишээ нь хүний эрхийн түүх ба онол гэсэн хичээл дараа жил эсвэл өмнөх жилд нь орсон бол окутан хэзээ нөхөн суухаа өөрөө шийдвэрлэнэ. Мөн ахисан түвшний сургалт, эсвэл тодорхой төрлийн сэдвээр хичээл сонгох бол өмнө нь ямар лекц, семинарт суусан байх талаар тодорхой шаардлага тавьдаг байна.

## **b) Австрали Улсын Картины Их Сургууль**

Австралид хүний эрхийн сургалтыг дээд боловсролын түвшинд олгох нь дараах онцлогтой. Цөөн тооны их сургуулиудад хүний эрхийг мэргэжлийн салбар харгалзахгүй өргөн хүрээнд хамруулан судалдаг бол ихэнх тохиолдолд энэ нь зөвхөн хуулийн факультетийн судлах зүйл байдаг. Гэвч энэ чиг хандлагад засгийн газрын зүгээс шүүмжлэлтэй хандаж байна. Тухайлбал Австралийн Боловсролын яамны сайд асан Жулиа Гиллард “Хүн бүр хүний эрхийн ойлголттой байж, түүнийг хэрэгжихэд өөрийн хувь нэмрийг оруулах явдлыг өөрсдийн амьдралын нэг хэсэг гэж үзэж чадвал сая хүний эрхийг хамгаалж, дэмжих явдал үр дүнтэй болно. Үүний тулд л бид хүний эрхийн боловсролыг үндэсний хэмжээнд хангах зорилт тавин жилд 12 сая долларыг зарцуулж байна”<sup>39</sup> гэж тэмдэглэн хэлсэн байдаг. Австрали улс хүний эрхийн талаар олон улсын ихэнх баримт бичигт нэгдэн орсон боловч үндэсний хууль тогтоомжид тусгах тал дээрээ өндөр хөгжилтэй орнуудын дунд доогуур байр эзэлдэг ба уугуул иргэд болон цагаач иргэдийн асуудлаар хангалттай арга хэмжээ авдаггүй гэж шүүмжлэгддэг<sup>40</sup>.

Картины их сургууль нь хүний эрхийн судалгааг дээд боловсролын түвшинд идэвхитэй дэмждэг сургуулийн нэг бөгөөд дэргэдээ Хүний Эрхийн Боловсролын Төвийг 2003 онд байгуулсан байна. Энэ төвийн гол зорилго нь хүний эрхийн боловсролыг хамгийн өргөн хүрээнд буюу салбар дундын мэдлэгийн хүрээнд (философи, улс төр, социологи, боловсрол, эрүүл мэнд, хууль, олон улсын харилцаа, сэтгэл зүй, антропологи, бизнес, хэвлэл мэдээлэл) олгоход оршино. Мөн бакалаврын дараах мастер, докторын

<sup>39</sup>Gillard, J. 2010. International Conference on Human Rights Education:([www.humanrightseducationconference2010.com.au](http://www.humanrightseducationconference2010.com.au)). Сүүлд нэвтэрсэн 2014.04.14

<sup>40</sup> Caroline Fleay, Linda Briskman. Human Rights Education at Curtin University: The Interconnections of Education, Research and Advocacy.

(<http://www.hurights.or.jp/archives/asiapacific/section1/16%20Caroline%20Fleay%20and%20Linda%20Briskman.pdf>)Сүүлд нэвтэрсэн 2014.05.02

сургалтыг хүний эрхийн чиглэлээр явуулдаг. Аль ч түвшний сургалтад онол, практикийг хосолж явуулахад онцгой анхаардаг байна. Үүний тулд сургалтын хөтөлбөрийг дээр өгүүлсэн салбар хоорондын мэдлэгт тулгуурлахаас гадна мэдлэгийг системтэй олгох хөтөлбөр боловсруулахыг зорьдог. Хүний эрхийн мастерын хөтөлбөрийг дараах дарааллаар боловсруулсан байна:

1. Хүний эрхийн философийн үндэс, чиг хандлага
2. Хүний эрхийг улс төрийн үзэл бодлын үүднээс тайлбарлах, улс төрийн үйл ажиллагаа хүний эрхийн зөрчилтэй хэрхэн холбогдож байгаа асуудлууд
3. Хүний эрхийн хөгжил ба түүхэн нөхцөл, НҮБ байгуулагдсан түүх, дэлхийн дайн, еврейн эсрэг үзлийг хэрхэн ойлгох, колонийн болдлого гэх мэт хүний эрхийг түүхэн үйл явцтай холбож тайлбарлах
4. Хүний эрхийг антропологиин үүднээс авч үзэхдээ барууны бус чиг хандлагаар тайлбарлах. Энэ нь жишээ нь муслим эмэгтэй бурка өмсөх нь хүний эрх хязгаарлагдаж байгаа хэрэг мөн эсэх зэрэг соёл, шашны учир шалтгаантай асуудлыг олон ургалч үүднээс тайлбарлах явдлыг дэмжиж, мэтгэлцээн өрнүүлэх зорилготой
5. Хүний эрхийг хамгаалах, механизм, НҮБ ба ТББ-уудын хамтын ажиллагаа, олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндэс, хамрах хүрээ
6. Эцэст нь хүний эрхийн чиглэлээр ямар практик үйл ажиллагаанд оролцох бүтээлч хандлагыг хөгжүүлэх, жишээ нь хүний эрхийн чиглэлээр хэвлэл мэдээлэл, соёл урлагийн үйл ажиллагаа зохион байгуулах гэм мэт боломжит бүх хувилбарыг дэмждэг.

Хүний эрхийн мастерын сургалт нь дипломын ажил бичих эсвэл хүний эрхийн чиглэлээр ажилладаг байгууллагад дадлага хийснээр дуусдаг байна.

### **3.2. Эх газрын эрх зүйн тогтолцооны онцлог: ХБНГУ-ын жишээнд**

Хүний эрхийн боловсрол гэсэн ойлголт нь ХБНГУ-ын хувьд дунд болон албан бус боловсролын хүрээнд хэрэглэгддэг.

Хууль зүйн дээд боловсролын хүрээнд Үндсэн хуулийн эрх зүй (Төрийн эрх зүй), Олон улсын эрх зүй, Европын эрх зүйн хүрээнд заавал судлах хичээлийн хэлбэрээр судлагддаг байна.

Төрийн эрх зүй нь Төрийн байгуулалтын эрх зүй, Үндсэн эрх, Олон улсын эрх зүй гэсэн гурван хэсэгт хуваагдан гурван семестрийн турш судлагддаг. Хүний үндсэн эрх төр ба иргэний хоорондын харилцаанд хөндөгддөг асуудал болохын хувьд төрөөс хүний эрхийг хангах, хамгаалах, хязгаарлах эрх зүйн үндэслэл, нөхцлийг Төрийн эрх зүй II буюу Үндсэн эрх гэсэн хичээлээр судалдаг. Мөн дээд ангийн оюутнуудад энэхүү хичээлийн гүнзгийрүүлсэн агуулгыг сонгох хичээлийн хэлбэрээр санал болгодог ба үүнд нийтийн эрх зүйн чиглэлээр мэргэшиж буй оюутнууд түлхүү хамрагддаг байна.

Олон Улсын эрх зүйн хүрээнд хүний эрхийг нийтлэг үнэт зүйл, эрх зүйн дэг журам болохынх нь хувьд судлах ба олон улсын хүний эрхийн талаарх эрх зүйн баримт бичгүүд, хамгаалалтын механизмыг практиктай холбогдуулан авч үздэг.

ХБНГУ нь Европын холбооны гишүүн улсын хувьд Европын эрх зүй Германы эрх зүйн тогтолцоонд чухал байр суурийг эзлэдэг. Тиймээс Европын эрх зүйн судлах зүйлийн чухал хэсгийг Европын холбоон дахь хүний эрхийн зохицуулалт эзэлдэг. Тухайлбал Европын зөвлөл ба Европын хүний эрхийн хамгаалалт гэсэн сэдвийн хүрээнд Европын зөвлөлийн зорилго, чиг үүрэг, Европын хүний эрхийн конвенц, Европын хүний эрхийн харта-ийн тухай болон Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээн дэх хүний эрхийн хамгаалалт зэргийг тусгайлан судалдаг. Түүнчлэн Европын шүүх ба Гишүүн улсуудын шүүхүүдийн харилцаа, шийдвэрүүдийн хүчин чадлын асуудал, улмаар гишүүн улсуудын төрийн бүрэн эрхийн асуудлууд ч өргөн агуулгатайгаар судлагддаг байна. Европын хүний эрхийн конвенц ба Европын хүний эрхийн шүүхийн талаар сонгох хичээл, сурах бичиг<sup>41</sup> бас байдаг.

Улсын шалгалтанд Төрийн эрх зүй нь нэг үндсэн хэсэг нь болдог тул мөн Үндсэн эрхийн асуудлууд улсын шалгалтын асуултанд ордог. Гэвч зарим судалгаанд <sup>42</sup> улсын шалгалтад хүний эрхийн агуулгыг илүү өргөнөөр тусгайлан оруулж өгөхгүй бол оюутнуудад тусгайлан судлах сонирхол төрөхгүй гэж шүүмжилжээ.

Үндсэн эрх хичээлийн агуулга<sup>43</sup>

1. Үндсэн эрхийн ойлголт ба энэхүү ойлголтын түүх: Энэ сэдвээр Үндсэн эрх хэмээх ойлголтын тодорхойлолт, ач холбогдол, Хойд Америк болон Франц дахь хүний эрхийн үүсэл, 19-р зууны Германы Үндсэн хуульт ёсны үеийн үндсэн эрхүүд, Ваймарын Бүгд Найрамдах Улсын Үндсэн хууль дахь үндсэн эрхүүд, одоогийн Үндсэн хууль дахь үндсэн эрхүүдийн хөгжил гэх мэт асуудлыг түүхэн уламжлал талаас нь авч үзжээ.
2. Үндсэн хууль дахь үндсэн эрхүүд: Энэ сэдвийн хүрээнд эхний ээлжинд муж улсуудын Үндсэн хуулиуд үндсэн эрхийг хэрхэн тусгаж байгаа тухай, дараа нь үндсэн хуулийн аль зүйл заалтад үндсэн эрхүүд болон холбогдолтой хэм хэмжээнүүд тусгагдсан талаар авч үзсэн. Ингэхдээ үндсэн эрх ба үндсэн эрхийн адил эрхүүдийн тухай, үндсэн эрх ба үндсэн эрхийн талаарх хэм хэмжээнүүд, үндсэн эрхийн бүлэг дэх төрийн байгуулалтын холбогдолтой хэм хэмжээнүүд гэж задлан тайлбарлажээ.
3. Үндсэн эрхийн чиг үүргүүд: Энэ сэдвээр үндсэн эрхийн сонгодог чиг үүргүүд болох “status negativus”, “status positivus”, “status activus”, “институтын баталгаа” зэргийн тухай, үндсэн эрхийн объектив эрхийн хувьд гүйцэтгэх төрийн эрх мэдлийг хязгаарлах, үнэт зүйлсийг

<sup>41</sup>Ch.Grabenwarter, Europäische Menschenrechtskonvention, 2. Aufl., 2005.

<sup>42</sup>Claudia Lohrenscheit/Nils Rosemann, Perspektiven entwickeln - Menschenrechtsbildung in Deutschland, 2003, (<http://www.institut-fuer-menschenrechte.de>).Сүүлд нэвтэрсэн 2014.05.30

<sup>43</sup> Pieroth/Schlink, Staatsrecht II: Grundrechte, 23. Aufl., 2007.

тодорхойлох, либерал эрх зүйт төрөөс социал эрх зүйт төрийн хэлбэрт шилжихэд нөлөөлсөн, эрх зүйн онол болон догмын хөгжилд нөлөөлөх зэрэг чиг үүргүүдийн тухай, үндсэн эрхийн хамгаалалтын чиг үүргүүд буюу хуулийг үндсэн эрхэд нийцүүлэн тайлбарлах, төрийн институтууд болон үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэх байдлаар иргэнийг хамгаалах, аливаа аюулаас хамгаалах чиг үүргүүдийн тухай дурдсан байна.

4. Үндсэн эрхийг эдлэх болон сахин биелүүлэх: Үндсэн эрх эдлэх тухайд хүний болон иргэний эрхийн тухай, төрхийн өмнөх болон нас барсны дараа эдлэх үндсэн эрх, үндсэн эрхийн чадамж, үндсэн эрхээсээ татгалзах, этгээдүүдийн нэгдэл болон байгууллага үндсэн эрх эдлэх тухай зэргийг авч үзнэ. Харин үндсэн эрхийг сахин биелүүлэх субъектүүд нь юуны өмнө төрийн байгууллагууд болох тухай, түүнчлэн хувь этгээдүүдийн сахин биелүүлэх үүрэг буюу үндсэн эрх гуравдагч этгээдэд нөлөөлөх тухай, энэ тарлаарх олон улсын аспектууд, мөн үндсэн үүрэг гэж байх шаардлагатай эсэх тухай авч үзжээ.
  5. Үндсэн эрхийг хангах болон хязгаарлах: Энэ сэдвээр үндсэн эрхийн хамгаалагдах хүрээ болон хангах үйл ажиллагааны тухай, үндсэн эрхэнд халдах, хязгаарлах, бусад холбогдох ойлголтуудын тухай, тэдгээрийн үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд зөвтгөх үндэслэлүүд болох хуулиар хязгаарлах шаардлага, хуулиар хязгаарлах шаардлага парламентаас хязгаарлах шаардлага болсон тухай, хуулиар хязгаарлах шаардлага хэр хэмжээнд нийцсэн хуулиар хязгаарлах шаардлага болсон тухай, хязгаарлалтыг хязгаарлах зохицуулалт (энэ хүрээнд хэр хэмжээнд нийцсэн байдлыг шалгах шалгууруудыг тухайлан авч үзнэ), үндсэн эрхийн зөрчилдөөн болон өрсөлдөөнийг хэрхэн шийдвэрлэх тухай зэргийг дэлгэрэнгүй авч үзжээ.
  6. Тухайлсан үндсэн эрхүүдийн хамгаалагдах хүрээ, халдах хэлбэрүүд, үндсэн хуулийн эрх зүйн зөвтгөлүүд гэсэн бүтэцтэйгээр тус бүрт нь судалдаг байна.
  7. Мөн зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар Үндсэн хуулийн шүүхэд үндсэн хуулийн гомдол гаргах эрхийн тухай дэлгэрэнгүй авч үздэг. ХБНГУ-ын хувьд Монгол улаас ялгаатай нь иргэн субъектив эрхийг нь төрийн байгууллагын зүгээс зөрчсөн гэж үзсэн тохиолдолд Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой. Тиймээс үндсэн хуулийн гомдлыг гаргахад тавигдах шаардлагууд, хэрхэн үндэслэх, хянан шийдвэрлэх арга ажиллагаанд суралцдаг байна.
- а) ХБНГУ- Бонн хотын Райны Фридрих Вилхелмийн Их Сургуулийн Төрийн ба эрхийн шинжлэх ухааны факультет

Эрх зүйг үндсэн мэргэжил болгон судлаж байгаа оюутнууд суурь, үндсэн, мэргэших, шалгалтанд бэлтгэх, бусад гэсэн сургалтуудад хамрагдна.

Суурь сургалтын хүрээнд Төрийн эрх зүй II буюу Үндсэн эрх хичээлийг 10 долоо хоногийн турш 4 цагаар судлахын хажуугаар үндсэн эрхийн талаарх бодлого бодох аргачлалд суралцуулах зорилго бүхий ажлын багуудад

хуваагдан долоо хоногийн 2 цагаар хичээллэж, төгсгөлд нь ангийн ажил бичдэг байна.

Үндсэн сургалтын үед Төрийн эрх зүй III буюу олон улсын эрх зүй, европын эрх зүйн Үндсэн хуулийн үндсийн тухай 12 долоо хоногийн турш 2 цагаар, Европын эрх зүй хичээлийг мөн адил хугацаагаар судлана. Мөн 18 долоо хоногийн турш 3 цагаар оролцож, төгсгөлд нь семинарын ажил бичиж, хоёр шалгалт өгдөг. Энэ хүрээнд үндсэн эрхийн асуудлууд, бодлогууд, шүүхийн шийдвэрүүдэд хууль зүйн дүгнэлтүүд өгөх зэргийг судлана. Мөн Төрийн эрх зүй III хичээлийн хүрээнд ажлын багуудад хуваагдан долоо хоногийн 2 цагаар хичээллэж, төгсгөлд нь ангийн ажил бичдэг байна.

Мэргэших сургалтын хүрээнд 2013-2014 оны өвлийн семестерт нийтийн эрх зүйн чиглэлээр Үндсэн эрхийн гүнзгийрүүлсэн сургалт, Олон улсын эрх зүй I, Хүний эрх ба олон улсын эдийн засгийн эрх зүй, Гэрлэгсэд ба гэр бүл – хувиран өөрчлөгдөж буй үндсэн хуулийн институт, Хүний эрхийн универсал байдал ба соёлын релятивизм, Эрх чөлөө ба өмч, Олон улсын эрх зүйг үндэсний шүүхүүдэд хэрэгжүүлэх нь гэх мэт хүний эрхтэй холбоотой сэдвүүдээр хичээл, семинарыг санал болгосон байна.

### 3.3. Хөгжингүй улсуудын онцлог: Азийн зарим улсуудын жишээнд

Хүний эрхийн хичээлийн хөтөлбөрийг хуулийн сургуулиудад хэрэгжүүлэх санаачлага Азийн улсуудад 2000-д оны эхнээс нилээд хүчтэй яригдах болсон байна<sup>44</sup>. Өмнөд Азийн хэд хэдэн улсууд (Бангладеш, Энэтхэг, Непал, Пакистан, Шри-Ланк) хамтран Өмнөд Азийн Хуулийн Сургуулиудын Хүний Эрхийн Форум (ӨАХСХЭФ)-ыг 2004 онд байгуулсан бөгөөд гол зорилгоо хүний эрхийн боловсролын ач холбогдлыг өндөрсгөх, бэхжүүлэх замаар хуулийн сургуулиудын сургалтын системд чанарын өөрчлөлт оруулах гэж тодорхойлжээ. Энэхүү форумгаас гаргасан баримт бичигт дараах зорилтыг тусгасан.

1. Хууль тэр дундаа хүний эрхийн чиглэлээр сургалт явуулдаг Зүүн Азийн хуулийн сургууль болон бусад ижил төстэй институцэд сургалтын чанарыг дээшлүүлж харилцан тушлага солилцох
2. Бүс нутагтаа хүний эрхийн тогтвортой хөгжлийг хангахын тулд хүний эрхийн талаар нийтлэг ойлголт бий болгох, их сургуулиудын хичээлийн хөтөлбөр, заах арга зүйг нийтлэг боловсруулах талаар хуулийн сургуулиудын идэвхитэй оролцоог хангах
3. Эрх зүйн боловсролыг нийгмийн бодит хэрэгцээнд тулгуурласан агуулгаар олгоход анхаарах
4. Хүний эрхийг хангах олон улсын болон бүс нутгийн механизмыг хэрэгжүүлэх, хөгжүүлэх үзлийг дэмжих,

<sup>44</sup>Jefferson R. Plantilla.ASIA: Promoting International Human Rights Standards. Sections of this article are from the paper of the author entitled Human Rights Education:Some Notes prepared for the Propagation and Implementation of Human Rights Conference held in Taipei, Taiwan on 3-5 December 2010. (<http://www.hurights.or.jp/archives/asia-pacific/section1/17%20Jefferson%20R.%20Plantilla.pdf>). Сүүлд нэвтэрсэн 2014.06.03.



5. Хүний эрхийг хөгжүүлэх нийтийн оролцоог дэмжих, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх талаар хуульчдын мэргэшлийг чадавхижуулах.

ӨАХСХЭФ нь дээрх зорилтоороо хүний эрхийн хөгжилд академик байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг ролийг ийнхүү чухалчилсан байна. ӨАХСХЭФ-тай төстэй зорилго бүхий Зүүн-Өмнөд Азийн Хүний Эрхийн Судалгааны Сүлжээ (The Southeast Asian Human Rights Studies Network) гэсэн байгууллага 2009 онд байгуулагдсан ба гишүүнчлэлд нь их сургуулиудын хуулийн факултет болон хуулийн сургуулиуд байдаг байна. Энэ байгууллагаас дээд сургуулиудад хүний эрхийн сургалт явуулах гарын авлага боловсруулах, эрдэмтэн судлаачдын дунд сургалт, семинар зохион байгуулах, Зүүн-Өмнөд Ази дахь хүний эрхийн судалгааг өргөжүүлэх, судлаачдын мэдлэг, чадавхийг дээшлүүлэх зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

#### **а) Энэтхэгийн Калкуттагийн их сургууль<sup>45</sup>**

Хүний эрхийн хөтөлбөрийг мастерын түвшинд боловсруулахдаа тухайн үндэстний соёлын онцлог, эдийн засгийн хөгжилтэй холбон тусгай хөтөлбөрөөр авч үзсэн Энэтхэгийн Калкуттагийн Их Сургуулийн жишээ байдаг. Уг хөтөлбөрийн үндэслэгч нь анторопологч Будхаб Чаудри юм. Тэрээр хүний эрх нь нийгмийн эмзэг давхарга буюу амьдралын хамгийн энгийн түвшинд хамгийн ихээр зөрчигдөж байгааг анзаарч энэ хөтөлбөрт заавал эрх зүйн профессор, доктор хичээл заах шаардлага тавиагүй. Харин амьдралын практик туршлагатай төрөл бүрийн мэргэжлийн багш хичээл заах ба хөтөлбөрт оролцож байгаа оюутнууд нь мөн төрөл бүрийн мэргэжилтэй хүмүүс байж болох тухай санаа дэвшүүлж амжилттай хэрэгжсэн ажээ. Энэ нь уг хөтөлбөрт хамрагдах хүмүүсийн тоо жил ирэх бүр нэмэгдэж байснаас харж болох юм. Хөтөлбөр 2 жилийн хугацаатай бөгөөд эхний жилдээ онолын мэдлэг олгоод 2 дахь жилээс аль нэг хүний эрхийн чиглэлийн байгууллагад дадлага хийж эцэст нь мастерын ажлаа бичиж дуусгах ёстой байдаг. Хөтөлбөрийн бас нэг онцлог нь хүний эрхийг судлахдаа салбар хоорондын мэдлэгийг ашиглахыг чухалчилсан. Үүнд:

1. Философи, түүх, соёлын хүчин зүйлүүд,
2. Хүний эрх ба ардчилал, олон ургалч үзэл, экологийн тэнцвэрт байдал, энхийг сахиулах ба дайны үйл ажиллагаа,
3. Үндэсний хэмжээнд хүний эрхийн асуудлыг авч үзэх: түүхэн нөхцлүүд, колончлолын өмнөх ба дараах үе, нийгмийн цөөнх эмзэг бүлгийнхнийг хамгаалах асуудлууд, төрийн эрх мэдлийн байгууллагуудаас гаргаж байгаа хүний эрхийн зөрчлүүд, зэвсэгт бүлэглэл ба террористуудын үйл ажиллагаа, жэндэрийн асуудлууд, нийгмийн бүлэглэл хоорондын зөрчил, Хүний эрхийн комисс ба ТББ-уудын үйл ажиллагаа,
4. Бүс нутгийн хэмжээнд хүний эрхийн асуудлыг авч үзэх: эдийн засгийн ядуурал, колончлолын дараах нийгмийн асуудлууд, өсөн нэмэгдэж байгаа хэрэглээ ба эдийн засаг, хүний эрх ба даяарчлалын асуудлууд,
5. Олон улсын хэмжээнд хүний эрхийн асуудлыг авч үзэх: хүний эрхийг хөгжүүлэх, хамгаалах чиглэлээр гарсан баримт бичиг, гэрээ хэлцэл,

<sup>45</sup> Human Rights as an Academic Discipline: Challenges and Opportunities.  
<http://www.hurights.or.jp/archives/pdf/asia-s-ed/v10/13HR%20as%20an%20Academic%20Discipline,%20Challenges%20and%20Opportunities.pdf>



НҮБ түүний салбар байгууллагуудын үйл ажиллагаа, тэдгээрийн алдаа оноо, туршлага.

Энэхүү мастериин хөтөлбөр нь:

1. Онолын хэсэг (эхний жил): Бичгийн ажил 1-5 (тус бүр 100 оноо)
2. Дадлагажих хэсэг (2 дахь жил): Бичгийн ажил 5-10 (тус бүр 100 оноо) гэсэн ерөнхий агуулгатай байх бөгөөд нийт 10 удаагийн бичгийн ажил гүйцэтгэнэ. Энэ нь тухайн бичгийн ажлын сэдвийг нэг жилд 2 удаа (Эхний ба 2 дахь хагас жил) холбогдох сэдвээр үзэж тус бүрд нь бичгийн ажил хийнэ гэсэн үг юм. Бичгийн ажлууд нь дараах сэдэвтэй байна.

Бичгийн ажил 1

Эхний хагас жил-Хүний эрхийн тухай ерөнхий ойлголт

-Хүний эрхийн хөгжил ба философи, түүх

2 дахь хагас жил-Социологийн онолууд

Бичгийн ажил 2

Эхний хагас жил-Хүний эрхийн хэм хэмжээ, механизм, арга хэрэгслүүд

2 дахь хагас жил-Хүний эрхийг хамгаалах арга зүй, нийгмийн үйл ажиллагаа

ба эв нэгдэл

Бичгийн ажил 3

Эхний хагас жил-Хүний эрх ба судалгааны арга зүй

2 дахь хагас жил-Иргэний нийгмийн үүсэл хөгжил

-Хүний эрх ба терроризм, дайны түрэмгийлэл, ардчилал ба энхийг сахиулах үйл ажиллагаа

Бичгийн ажил 4

Эхний хагас жил-Хүний эрх ба даяарчлал

-Хэрэглэгчийн эрх

2 дахь хагас жил -Хүний эрх ба угсаатны болон бүлгийн асуудал,

-Хүний эрх ба эрүү шүүлт

Бичгийн ажил 5

Эхний хагас жил-Хүний эрх ба эмзэг бүлэг

-Эмэгтэйчүүд, хүүхэд ба хүний эрх

2 дахь хагас жил-Хүний эрх ба экологи, боловсрол, эрүүл мэнд

Бичгийн ажил 6-Судалгааны илтгэх тайлан

Бичгийн ажил 7-Дадлагын тайлан

Бичгийн ажил 8

Эхний хагас жил-Хүний эрхийн асуудлаарх шүүхийн нэхэмжлэл, баримтат эх сурвалж судлах (дор хаяж 3 хэрэг тохиолдол)

2 дахь хагас жил-Судалгааны дүгнэлт шүүмжлэл

Бичгийн ажил 9 ба 10-Мастерын ажил

ЦИН.МН  
СУДАЛГААНЫ САН

## **b) Хонгконгийн их сургууль<sup>46</sup>**

Хонгконг 1997 онд Хятадын мэдэлд очсонтой холбоотой эрх баригчид нь хүний эрх, эрх чөлөө хумигдахаас сэргийлэх, энэ талаар бусад улсууд ядлангуяа Ази-Номхон далайн орнуудтай хамтын ажиллагааг өрнүүлэх үүднээс хүний эрхийн чиглэлээр мастерийн зэрэг олгох хөтөлбөрийг 1999 оноос эхлэн Хонгконгийн их сургуулийн хуулийн факультетад хэрэгжүүлж эхэлсэн байна.

Хөтөлбөрт эрх зүйн чиглэлээр болон бусад төрөл бүрийн мэргэжлээр суралцсан хүмүүс хамрагдаж эхэлсэн бөгөөд тэдний сонирхол нь өөрсдийн мэргэжлийн чиглэлд хүний эрхийн хандлага, үзэл баримтлалыг таньж мэдэн, суралцахад оршиж байгаа ажээ. Хичээл англи хэлээр явагдах бөгөөд 1 ба 2 жилийн хөтөлбөртэй. Оюутнууд нийт 8 төрлийн хичээл сонгох ёстой бөгөөд дараах агуулгыг заавал багтаах ёстой.

1. Олон улсын бүс нутгийн хүний эрхийн стандарт, механизмыг судлаж, эдгээр нь үндэсний хэмжээнд хэрхэн хэрэгжих талаар гүн бат мэдлэгтэй болох,
2. Хүний эрхийн үүсэл, хөгжил, түүний философийн үндэс, бүхий л түвшинд хүний эрх хэрэгжихэд улс төр хэрхэн нөлөөлдөг талаар судлах.

Эхний жилийн хөтөлбөрт олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн тогтолцоо, НҮБ-ын хүний эрхийг хамгаалах тогтолцоо ба олон улсын эрх зүйн хэм хэмжээ, түүний хэрэгжих механизмууд, хүний эрхийн олон улсын гэрээ конвенцүүд ба зөрчигдсэн эрхийг сэргээхэд шүүхийн тогтолцоог хэрхэн ашиглах талаар тухайлсан хэрэг тохиолдол дээр судлах, тэдгээрийг түүхэн, онолын, улс төрийн хүрээнд авч үзэхэд суралцдаг байна. 2 дахь жилдээ үндэсний хэмжээнд хүний эрхийг хамгаалах механизмыг Үндсэн хууль, бусад хууль, захиргааны хэм хэмжээний хүрээнд авч үзэх бөгөөд эдгээрийг хэрэгжүүлэхэд хүний эрхийн үндэсний комисс, шүүх, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд болон иргэний нийгмийн чиг үүрэг оролцоо ямар байх ёстой талаар судалдаг. Сүүлийн жилүүдэд хөтөлбөрийг илүү нарийвчилсан сэдвээр гүнзгийрэн суралцах боломжийг бий болгохыг зорьж байгаа ажээ. Тухайлбал: Бизнес ба хүний эрх, Харьцуулсан үндсэн хуулийн эрх зүй, Хятад дахь авилгалын асуудлуудыг харьцуулсан эрх зүйн үүднээс дүгнэх нь, Хүний эрх ба орчин үе, Тэгш эрх ба үл ялгаварлах үзэл, Хүний эрх ба ардчилал, Хүний эрхийг судлах арга зүй ба онол, Олон улсын гэмт хэргийн эрх зүй, Олон улсын экологийн эрх зүй, Олон улсын хүмүүнлэгийн эрх зүй, Дүрвэгсэд ба олон улсын эрх зүй, Соёлын олон янз ба олон улсын эрх зүй, Хүүхдийн эрх гэх мэт.

### **3.4. Сэдвийн дүгнэлт**

Судалгаанд хамрагдсан эрх зүй, хүний эрхийн хөгжлийн түвшин янз бүр улсуудын хуулийн сургуульд хэрэгжиж байгаа хүний эрхийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг дараах ерөнхий ангилалд хуваан харж болохоор байна. Үүнд:

<sup>46</sup> Kelley Loper. Reflections on a Master of Laws in Human Rights Program in Asia. Article presented at the International Conference on Human Rights Education at the University of Western Sydney. 4<sup>th</sup> November of 2010. ([www.hku.hk/law/download/HR.pdf](http://www.hku.hk/law/download/HR.pdf)). Сүүлд нэвтэрсэн 2014.06.02.

- А. - Олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд
  - Үндсэн хуулийн хүний эрхийн заалтын хүрээнд
  - Үндэсний хэмжээнд гарч байгаа хүний эрхийн зөрчлийн хүрээнд

- Б. - Хүний эрхийн зөрчлийн тохиолдлыг олон улсын практикт харьцуулан авч үзэх
  - Хүний эрхийг салбар хоорондын мэдлэг дээр үндэслэн хөгжүүлэх

Хуулийн сургуулиудын бакалаврын хөтөлбөрт хүний эрхийн сургалтыг хэрхэн тусгах талаар өндөр хөгжилтэй орнуудад нэгэнт тогтсон загвар, аргачлалтай байдаг бол хөгжингүй улсуудын хувьд ийм боломж, нөхцөл хязгаарлагдмал байж болох юм. Учир нь хүний эрх нь бүхий л салбар эрх зүйн хувьд суурь ойлголт, зарчим болж өгдөг тул эрхийн соёл, эрх дээдлэх ёс, хуулийн сургалтын уламжлал зэрэг нь ямар түвшинд, хэрхэн хөгжиж ирсэн нь хүний эрхийн сургалтын агуулгад ихээхэн нөлөөтэй байна. Тухайлбал, хөгжингүй улсуудын хувьд дээрх ангиллын А хэсэгт байгаа хүрээнд хүний эрхийн сургалтын хөтөлбөрийг боловсруулдаг нийтлэг дүр зураг харагдаж байгаа бол Америк, Герман зэрэг өндөр хөгжилтэй орнуудын хувьд А ба Б ангиллыг хамрахын зэрэгцээ практик сургалтын арга зүйг дэмжихэд илүү анхаарч байна. Онцлон тэмдэглэхэд ихэнх улсуудын хувьд хүний эрхийг тусад нь тусгай бие даасан хичээл гэж авч үзэхгүйгээр холбогдох шинжлэх ухаан, бусад салбар эрх зүйтэй хавсран судлах нийтлэг чиг хандлага байна.

Хүний эрх гэдэгт юуг хамааруулах, ямар тодорхойлолтын хүрээнд авч үзэх талаар хөгжингүй улсуудын хувьд нэг мөр ойлголтод хүрэхэд хүндрэлтэй байдаг байна. Тухайлбал, хүний эрхийг тайлбарлахад Азийн (үндэсний) онцлог гэдэг ойлголт дор хүний эрхийн нийтлэг хэм хэмжээг дордуулан тайлбарлах явдлаас татгалзах нь зүйтэй бөгөөд хүний эрхийг нийтлэг, түгээмэл хэм хэмжээ гэж үзэх чиг хандлагыг хуулийн сургуулиудад хөхиүлэн дэмжих ёстой гэж судлаачид үздэг байна<sup>47</sup>. Энэ талаар дэлхий нийтийн нийтлэг чиг хандлагад ойртоход бүс нутгийн буюу Азийн хуулийн сургуулиудын хамтын ажиллагаа дэвшил авчирч байгаа хэдий ч хүний эрхийн сургалтыг явуулах аргачлал, арга зүй сул байгаа гэж үзэх нь нийтлэг байна. Тухайлбал, хуулийн сургуульд хүний эрхийн ойлголт, хамгаалах арга механизмыг зөвхөн өөрийн улсын хууль тогтоомжийн хүрээнд бус баталсан эсвэл нэгдэн орсноос үл хамааран бусад олон улсын гэрээ хэлцэлд хүний эрхийн талаар заасан дэвшилтэт хэм хэмжээг мөн адил сургалтад оруулж байх нь хүний эрхийн хөгжилд дэвшил авчрах чухал аргачлал юм гэдэгт олонх судлаачид санал нэгтэй байдаг<sup>48</sup>.

Азийн хөгжингүй орнуудад хүний эрхийн хичээл хуулийн сургуулиудад орж эхлээд удаагүй байгаа хэдий ч нэг онцлог нь хүний эрхийн ямар зөрчил тухайн улсад хамгийн ихээр асуудал болж байгааг олж хараад түүн дээрээ судалгаа, сургалтаа төвлөрүүлж байна. Энэтхэгт гарч байгаа хүйсийн болон нийгмийн гарал үүслийн ялгаварлал, Индонезийн шашны асуудал, Хятадын

<sup>47</sup> Jefferson Plantilla Teachin human rights. The cultural question. (<http://www.hurights.or.jp/archives/asia-pacific/section1/pdf/10%20-%20Teaching%20Human%20Rights.The%20Culture%20Issue.pdf>). Сүүлд нэвтэрсэн 2014.05.06.

<sup>48</sup>R. Herlambang Perdana Wiratraman. The Dynamics of Human Rights Education in Indonesian Law Schools. (<http://www.hurights.or.jp/archives/pdf/asiased/v10/10The%20Dynamics%20of%20HRE%20in%20Indonesian%20Law%20Schools.pdf>). Сүүлд нэвтэрсэн 2014.06.10.

улс төрийн эрхийн зөрчил зэрэгтэй адил дэлхий нийтийн анхаарлыг татаж байдаг хүний эрхийн хурц асуудал манай улсад байхгүй хэдий ч бид эдгээр улсууд өөрсдийн асуудлыг хэрхэн дэвшүүлж, түүн дээрээ тулгуурлан хүний эрхийн боловсролыг хөгжүүлж байгаа практик туршлагаас суралцах нь зүйтэй юм. Үүнд бүс нутгийн их сургуулиудын хамтын ажиллагааны байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох нь чухал ач холбогдолтой. Мөн өндөр хөгжилтэй улсуудаас эрх зүйн аль системд хамаарч байгаагаас үл хамааран хуулийн сургуулиудад хүний эрхийн сургалтын хөтөлбөрийн агуулга, судалгаа, сургалтын арга зүй аргачлал, боловсруулах талаар суралцаж, өөрийн орны онцлогт тулгуурлан бүтээлчээр хөгжүүлэх шаардлага нэн их байна.

## ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

НҮБ-ын ХЭБДХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө, эрх зүйч бэлтгэж буй их, дээд сургуулиудад хүний эрхийн боловсрол олгож буй байдал, сургалтын хөтөлбөр дэх “Хүний эрх” хичээлийн хөтөлбөр, бусад улс орнуудын их, дээд сургуулиудын туршлага зэрэгт хийсэн судалгааг үндэслэн тодорхой чиглэлээр бодлогын түвшний шийдвэр гаргах, хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Учир нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнүүд, НҮБ-ын ХЭБДХ, дэлхийн бусад улсуудын хуулийн их, дээд сургуулиудын туршлагаас анхааран үзвэл энэхүү салбарт хүний эрхийн боловсролыг цаашид хөгжүүлэх, өргөжүүлэх өргөн боломж байна.

Энэхүү судалгааны үр дүнг үндэслэн Засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яам болон эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудын зүгээс дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь зөв юм.

### Нэг. Засгийн газар, Боловсрол, шинжлэх ухааны яам:

1. Хууль зүйн төдийгүй, нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол олгож буй сургуулиудад хүний эрхийн агуулгыг нийтлэг байдлаар тусгах стратеги, стандарт боловсруулж батлуулах, “Хүний эрх” хичээлийг бусад дээд боловсролын байгууллагуудын сургалтын төлөвлөгөөнд оруулах бодлого баримтлах;
2. Эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудад “Хүний эрх” хичээлийг заавал үзэх мэргэжлийн суурь хичээлийн жагсаалтад оруулах, эрх зүйн бакалавр, магистрын сургалтын хөтөлбөр, түүний агуулгыг хүний эрхэд суурилсан хандлагаар шинэчлэн боловсруулж, хэрэгжилтэд нь хяналт тавих;
3. Эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиудад хүний эрхийн магистр, докторын хөтөлбөртэй болох асуудалд дэмжлэг үзүүлэх;
4. Эрх зүйн боловсрол олгож буй хуулийн их, дээд сургуулиудыг магадлан итгэмжлэх, тусгай зөвшөөрөл олгохдоо тухайн сургуулийн хүний эрхийн сургалтыг шалгуур үзүүлэлт болгон үнэлэх асуудлыг журамлах;
5. Эрх зүйн боловсрол олгож буй их дээд сургуулиудад “Хүний эрх” хичээлийн нэгдсэн нэг сургалтын хөтөлбөр, сургалтын гарын авлагатай болох;
6. НҮБ-ын Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллах.

### Хоёр. Эрх зүйн боловсрол олгож буй их, дээд сургуулиуд:

1. Сургуулийн бүхий л багш нарыг хүний эрхийн чиглэлээр мэргэшүүлэх, тусгайлан мэргэшсэн багш, боловсон хүчнээр “Хүний эрх” хичээлийг заалгах, ХЭҮК-ын ажилтнуудаар “Хүний эрх” хичээлийг заалгах боломжийг бүрдүүлэх;
2. “Хүний эрх” хичээлийн хөтөлбөр, агуулгыг ХЭҮК-оос боловсруулсан “Хүний эрх” хичээлийн загвар хөтөлбөр, НҮБ-ын холбогдох баримт бичгүүд, орчин үеийн онолын чиг хандлагад нийцүүлэн тогтмол шинэчилж байх;
3. Мэргэшлийн суурь хичээлүүдийн хэрэглэгдэхүүнийг хүний эрхийн зарчимд нийцүүлэн шинэчлэн сайжруулах;
4. Сургуулийн дотоод зохион байгуулалт, удирдлага, багш, оюутнуудын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журмыг боловсруулахдаа хүний эрхийн зарчимд нийцүүлэх, сургуулийн дотоодод хүний эрхийн соёлыг төлөвшүүлэх;
5. Хүний эрх хичээлийг заах багшийг тусгайлан бэлтгэх, хүний эрхийн сургагч багшийн сургалтад хамруулах, мэргэшүүлэх;
6. Сургууль дээрээ хүний эрхийн чиглэлээр сайн дурын үйл ажиллагаа явуулах сонирхолтой болон тиймүйл ажиллагаа зохион байгуулж буй оюутнуудыг дэмжих, хөгжүүлэх;
7. Хүний эрхийн мэдрэмжтэй мэргэжилтэн бэлтгэхэд ХЭҮК-той хамтран ажиллах;
8. Ижил төсөөтэй дэлхийн бусад улсын их, дээд сургуулиудын хүний эрхийн боловсролын сайн туршлагаас суралцах, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх.

